

ЗҮҮН ХОЙД АЗИЙН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ГЭРЭЭ БА МОНГОЛ

ТОВЧ АГУУЛАГА

Шинэ шинж чанарыг агуулсан бүс нутгийн худалдааны гэрээ байгуулах явц эрчимжлээ. Энэ үйл явц нь Монгол улс шиг хөгжиж буй улсуудад харьцангуй давуу талаа ашиглах өргөн бололцоо олгож байна. Монголын эдийн засгийн болон нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, мөн өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцыг хөнгөвчлөх нэг чухал хэрэгсэл нь дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн интеграцид бүрэн хамрагдах явдал хэмээн үзэж байна. Тийм ч учраас Монгол улс Зүүн хойд Ази /ЗХА/ дахь эдийн засгийн хамтын ажиллагааг сонирхож байна. Энэ бүс нутаг дахь эдийн засгийн хамтын

ажиллагаа, интеграцийн процесс нь одоохондоо эдийн засгийн гэхээсээ илүү улс төрийн хүчин зүйлс, гол гол оролцогчдын хоёр талын харилцаанаас илүү их хамааралтай байгаа юм.

Гэсэн хэдий ч ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаа нь гол төлөв бүс нутгийн түлхүүр тоглогчийн улс төрийн бодлого мөн хоёр талын харилцан ажиллагаагаар тодорхойлогдох болно.

Гипотетик ЗХА-ийг зах зээлд интеграцчлагдах болон Япон улстай ЧХГ байгуулсан нөхцөлд Монголын гадаад худалдаа ямархуу байж болох хувилбарыг гравитацийн загвар ашиглан хийсэн судалгааг энд танилцуулна.

JEL ангилал: F15, H56, H77, P26

Үндсэн нэр томъёо: Монгол, шилжилт, ЧХГ

Энэхүү судалгааг Нээлттэй Нийгэм Форумын санхүүгийн дэмжлэгтэйгээр хийсэн бөгөөд судалгааны явцад дэмжлэг үзүүлсэн тус Форумын Гүйцэтгэх Захирал П.Эрдэнэжаргал, менежер Б.Мөнхсоёл нарт талархал илэрхийлье. Энэ бичигдсэн зүйлс нь зөвхөн судлаачийн хувийн үнэлэлт дүгнэлт юм.

Р.Амаржаргал
E-mail: arinchin@yahoo.com

ОРШИЛ

Зохиомлоор үүсгэсэн эдийн засгийн бүтэцтэй (ДНБ-д аж үйлдвэрийн эзлэх хувийн жин 33.2 хувь, суурин хүн амын тоо бараг 60 хувь, СЭВ-ын орнуудаас гадаад худалдааны хамаарал нь 97 хувьд хүрсэн) Монгол улс 1990 оноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж эхэлсэн билээ. Тухайн үедээ, 7.6 дахин реплэслэгдсэн инфляцын түвшин, албан болон хар захын валютын ханшийн зөрүү нь

1400 хувь хүрч, гадаад худалдааны нөхцөл эрс муудсан зэрэг нь эдийн засгийн гажуудлыг илэрхийлж байсан юм. Түүнчлэн, эдийн засгийн иж бүрэн шинэтгэлийн туршлагагүй, зах зээлийн тогтолцооны институциональ ой санамж устаж үгүй болсон, газар зүйн байршил нь сул тал болж хувирсан зэрэг нь энэхүү шилжилтийг улам хүндрүүлсэн юм.

Их хямрал, дайны үе, шилжилтийн үеийн үндэсний худалдан авах чадварын уналтын харьцуулалт (ДНБ %-иар)

Хүснэгт-1.

		Гадаад санхүү	ДНБ дэхь өөрчлөлт	Худалдааны нөхцөл	Нийлбэр дүн
<i>Хуучин социалист орнууд</i>					
Монгол	1989-1991	-37.1	-18.0	-6.6	-61.7
Чехословак	1989-1991	0.0	-18.6	-5.4	-24.0
Унгар	1989-1991	0.0	-11.2	-3.7	-14.9
Польш	1989-1991	0.0	-19.9	-2.9	-22.8
<i>Их хямрал</i>					
Франц	1929-1932	1.1	-14.6	Na	-13.5
Герман	1929-1932	1.3	-19.1	Na	-17.8
Их Британи	1929-1932	-4.3	-17.8	Na	-22.1
АНУ	1929-1933	0.0	-32.6	Na	-32.6
<i>Дайны үе</i>					
Австри	1937-1946	Na	-36.0	Na	-36.0
Итали	1938-1946	Na	-49.7	Na	-49.7
Япон	1938-1946	Na	-50.5	Na	50.5
Испаний иргэний дайн	1935-1940	Na	-25.7	Na	-25.7
ЗХУ	1938-1946	Na	-8.3	Na	-8.3

Эх сурвалж: Р. Вооне 1994:331.

Жил бүр эдийн засгийн бараг 1/3-тэй нь тэнцэх “тусламж дэмжлэг” үзүүлдэг байсан СЭВ, ЗХУ задармагц Монголын эдийн засаг үндсэндээ нурж билээ.

Монгол улс орчин цагийн дэлхийн түүхэнд байгаагүй шок-той тулгарсан юм. Их хямралын Америк, дайны үеийн Япон, Итали, шилжилтийн үеийн Польш, Чехословакаас ч илүү эдийн засгийн уналт, сүйрэлтэй тулгарсан юм /Хүснэгт-1/.

Монгол улс эдийн засгийн болон улс төрийн шилжилт, шинэтгэлээ нэгэн зэрэг эхлүүлж, ардчилсан институт бүрдүүлэх, макро эдийн засгийн тогтворжуулалтыг хангах, эдийн засгийн дотоод гадаад либералчлал мөн өмч хувьчлал зэрэг үйл явцад 10 гаруй жил зарцуулсан.

Ямар үр дүнд хүрэв? 1993 онд бараг 400 хувь хүрч байсан инфляци нэг оронтой болж, 1990 онд бараг байгаагүй хувийн сектор ДНБ-ий 80 хувийг бүрдүүлдэг болжээ. 1994/1995 оноос эхлэн эдийн засаг өсөж, хямралын өмнөх түвшиндээ 2000 онд хүрсэн юм.

Амжилт ололт илт байгаа хэдий ч шийдлээ хүлээж буй хэдэн том асуудал байна. Үүний дотор хамгийн түрүүнд ядуурал анхаарал татаж байгаа юм. Хэдийгээр ядуурлын түвшин 1998-2000 онуудад тогтворжин, түүнээс хойш нэмэгдэхгүй байгаа ч өнөөгийн тулгамдсан асуудал хэвээр байсаар байна. Асуудлыг эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах

замаар шийднэ гэж үзэж байгаа бөгөөд энэхүү өсөлтийг хангахуйц эдийн засгийн шинэтгэлүүд, тухайлбал, бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх шаардлагатай байгаа юм. Энэ утгаараа, дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн интеграцид хамрагдах, түүнд идэвхитэй оролцох, ЧХГ байгуулах замаар хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг нь эдийн засгийн бодлогын салшгүй нэг хэсэг байх ёстой.

Stanley Fischer et al. (2000) зүүн Европын экс социалист орнуудын хувьд “... Европын холбоонд нэгдэх ирээдүй нь /эдийн засгийн/ шинэтгэлээ эрчимжүүлэхэд хүчтэй түлхэц болж өгнө” гэж үзэж байсан бол Gerard Roland (2001) Европын холбоонд элсэх магадлал нь “өмчийн эрхийг баталгаажуулахад” ач холбогдолтой гэж байсан юм. Үнэхээр ч, Зүүн Европын экс социалист орнуудад, улс төрийн аль хүчин засгийн эрхэнд байхаас үл хамааран, эдийн засгийн шинэтгэлийг тууштай хэрэгжүүлснээр “соёлжсон ертөнцөд” нэгдэх асар их эрмэлзэлээ хангаж чадсан билээ. Харин Монгол улсын хувьд иймэрхүү гадаад сэдэц, “урамшуулах” хүчин зүйл байгаагүйгээс гадна ЕХ шиг институт Азид ч байхгүй юм.

Социалист байсан орнуудад өрнөж байгаа процессыг судлаачид трансформаци гэж нэрлэж байгаа бөгөөд шинэ нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлсийг бүрдүүлэх асуудлыг хүртэл тусгаж байгаа юм. (Gerard Roland 2001; Jeffrey Sachs, Wing Thye Woo and Xiaokai

Yang, 2000). Энэ утгаараа Монгол улс нь иж бүрэн гүн гүнзгий шинэтгэлээ эрчимжүүлэх ёстой бөгөөд өнөөгийн шатанд зах зээлийн “зөөлөн дэд бүтцийг” бүрдүүлэхэд онцгой анхаарах ёстой. Хөгжлийн өнөөгийн шатандаа тулгамдаад буй асуудлыг Монгол улс дангаараа шийдэх бололцоогүй учраас бүс нутгийн болон дэлхийн эдийн засгийн интеграцийн боломжийг ашиглах ёстой.

Энэхүү илтгэлийн эхний хэсэгт бүс нутгийн хамтын ажиллагаа болон ЧХГ-ний зарим асуудлыг товчхон хөндөж, хөгжиж буй улс

орнуудын хувьд харьцангуй давуу талаа тодорхойлоход ЧХГ чухал болох талаар саналаа илэрхийлсэн, хоёрдугаар хэсэгт, Монгол улсын эрх ашгийн үүднээс ЗХА-д өрнөж буй зарим улс төр, эдийн засгийн үйл явцыг танилцуулж, гуравдугаар хэсэгт Япон улс ЧХГ-д хэрхэн хандаж ирснийг жишээ болгон үзүүлж, төгсгөлийн хэсэгт нь хэрвээ Монгол улс гипотетик маягаар ЗХА-ийн интеграцид нэгдэх болон Япон улстай ЧХГ байгуулбал ямар үр дүнд хүрч болохыг таамагласан загвар танилцуулсан болно.

I. БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ЧХГ-ний ЗАРИМ АСУУДЛУУД

Дэлхийн худалдааны байгууллагын /ДХБ/ үзэж байгаагаар бүс нутгийн худалдааны гэрээ урьд өмнө байгаагүй өргөн дэлгэрч байна. 2006 оны байдлаар бараг 370 бүс нутгийн хэлэлцээр бүртгэгдсэн бөгөөд үүнээс 214 нь ГАТТ-ын XXIV зүйлд хамааралтай байна. (The Changing Landscape of Regional Trade Agreements: 2006 Update. www.wto.org) Өнөө үеийн Бүс Нутгийн Худалдааны хэлэлцээр нь /БНХХ/ хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн хамтын ажиллагаа, макро эдийн засгийн бодлогын зохицуулалт, үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн хөдөлгөөнт чанар, оюуны өмчийн эрх, карантин, аялал жуулчлал, үйлчилгээний салбар зэрэг өргөн хүрээг хамрах болжээ.

БНХХ нь олон талт худалдааны системийг дагалдсан бөгөөд нөхөж байгаа гэдгийг ДХБ хүлээн зөвшөөрч байна. Шинэ БНХХ олон

талт хэлэлцээрээс илүү уян хатан чанартай бөгөөд ЧХГ нь том гүрнүүдийг жижиг нь “дуугүй дагадаг” байсан асуудлыг ямар нэгэн байдлаар шийдэж байгаа юм.

БНХХ-ийн арилжаа наймааг шилжүүлэх /зайлуулах/ үр дагавар нь судалгааны гол цөм байдаг. Гэхдээ БНХХ нь шинэ чиг хандлага, шинж чанарыг агуулж буй учраас бүс нутгийн интеграцийн асуудлыг ч бас өргөн цар хүрээнд авч үзэх шаардлагатай болжээ. Тухайлбал, шинээр хийгдэж буй БНХХ-ийн цаана буй улс төрийн агуулга өмнөхөөсөө илт нэмэгдсэн байна. Тиймээс БНХХ судлахдаа улс төрийн институтыг тооцох шаардлага зайлшгүй гарч байгаа юм. Түүнчлэн глобальчлал, технологийн хөгжил дэвшил, геополитикийн хүчин зүйлсийг тусгах хэрэгтэй.



Stanley Fischer “дэлхийн эдийн засгийн нэгдэл нь улс орнуудын хөгжих хамгийн шилдэг зам” гэж үзэж байна. (Rodrik Dani, 2000 ишлэл авсан). Гэсэн хэдий ч арилжаа худалдаа нь эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлж байгаа талаар судлаачид нэгдсэн ойлголтод хүрээгүй юм. Энэ нь судалгааны зорилго, цар хүрээ, ашиглаж буй өгөгдөхүүний чанараас хамаарч байгаа гэж Baldwin, Robert E (2002) үзэж байх жишээтэй.

Dani Rodrik (2000), дэлхийн эдийн засаг интеграцчлагдах нь өндөр өртөгтэй, мөн “хөгжлийн альтернатив чиглэлийг хаагаад зогсохгүй, нэн тулгамдсан асуудлыг шийдэх ёстой ажиллах хүч, захиргааны хүчин чадал, улс төрийн капиталыг өөр тийш нь шилжүүлдэг” гэж шүүмжилсэн байна.

Олон талт хэлэлцээрийг дэмждэг (жишээ нь, Bhagwati Jagdish ed., 2002) судлаачдын байр суурийг зохиогчийн авч үзэж байгаа урьдчилсан нөхцөлтэй уялдуулан хүлээн зөвшөөрч бас болох ч, амьдрал өөрөө аливаа загвараас хамаагүй баян байдаг бөгөөд онолын зарим нэгэн урьдчилсан нөхцөл тусгагдсан байгаа учраас ЧХГ-г үгүйсгэнэ гэдэг нь шийдэл биш юм.

Олон улсын худалдаа нь харьцангуй давуу тал дээр тулгуурласан бөгөөд дотооддоо эдийн засгийн дагналтыг гүнзгийрүүлэх замаар үр ашгийг нь нэмэгдүүлдэг (Grossman, G.M.; Helpman, E, 1990). БНХХ-ээр дамжин эдийн

засгийн болон худалдааны хэлхээ холбоо нягтрах нь олон улсын хэмжээнд хөдөлмөрийн хуваарь, дагналтыг гүнзгийрүүлэн улмаар зах зээлийг өргөжүүлдэг юм. (Xiaokai Yang and Dingsheng Zhang September 2001:5). БНХХ-ийн энэхүү шинж чанар нь хөгжиж буй орнуудад нэн ач холбогдолтой билээ. БНХХ-д нэгдэх нь худалдаа арилжааг либералчилж байгаа нэг хэлбэр бөгөөд шинээр харьцангуй давуу тал олох, нээх бололцоог хөгжиж буй орнуудад олгож байгаа юм. Хэдий чинээ харьцангуй давуу талууд шинээр илэрнэ төдий чинээ газар зүйн байршил, хүн амын тоо гэх мэт байгалийн хязгаарлагч хүчин зүйлсийн сөрөг үр нөлөө буурах юм.

Мэдлэг дамжуулах, биет болон хүний капитал хуримтлуулах, дотоод шинэтгэлийг эрчимжүүлэх зэргээр БНХХ-ийн динамик шинж чанар нь илэрдэг юм. Жишээ нь, ЧХГ-ээс үүдэн тарифын орлого буурах нь төсвийн шинэтгэл хийх нэг хүчтэй түлхэц болно. Түүнчлэн ЧХГ нь дотоод гадаадын хөрөнгө оруулагчдыг татан, тэдний үйл хөдлөлийг өөрчлөх чадвартай (Emiko Fukase and L.Alan Winters 1999). Өөр нэг жишээ авья. Японы компаниуд удирдлагын болон маркетингийн нарийн ур чадвартай бөгөөд санхүүгийн зах зээлд гарцтай. Гэсэн хэдий ч дотоодын зах зээл дэх өрсөлдөөний улмаас “үл мэдрэгдэх активтай” эдгээр компаниуд гадаадад үйл ажиллагаа өрнүүлэх сэдэц эрмэлзэлтэй болно. Нөгөө талаас хүлээн авч байгаа улс нь хөрөнгийн баталгаа гэх мэт хөнгөлөлт баталгаа

гаргаж өгвөл аль аль талдаа ашигтай болж БНХХ-ийн бололцоо бүрэн нээгдэх юм.

Буурай хөгжилтэй орны хувьд хязгаарлагдмал санхүүгийн нөөцөө хааш нь чиглүүлэх, хааш нь хөрөнгө оруулалт хийнэ гэдэг нь өгөгдсөн “материалын” хүрээнд дагнах салбараа, харьцангуй давуу талаа тодорхойлж байна гэсэн үг. Хөгжилтэй улсуудыг дуурайсан хөрөнгө оруулалт нь амжилтын баталгаа биш юм. Харин хөгжилтэй орнуудтай нягт хамтран ажиллаж байж харилцан нөхсөн эдийн засгийн бүтцийг тодорхой болгож авна.

Бүс нутгийн хөгжлийн асуудал нь эдийн засгийн интеграци болон улс төрийн хамтын ажиллагааг шаардсан олон хэмжүүрт, олон үе шаттай процесс билээ. Эдийн засгийн үр ашигтай хамтын ажиллагааны орчин бүрдүүлэхээс эхлээд эл процессыг залах, уялдуулах үүрэг бүхий институт байгуулах хүртэл олон үе шатыг дамжина. Бүс нутгийн хамтын ажиллагаанд саад болж буй хүчин зүйлсийн дотор улс төрийн сул итгэлцэл, санхүүгийн шаардлага харилцан адилгүй

зэргийг дурьдаж болно. (Schiff and Winters 2002). Энэ хүрээнд Walter Mattli интеграцийн эрэлт нийлүүлэлтийг хангах нөхцөл чухал болохыг дурьдсан байдаг. Тэрээр нийлүүлэлт талд нь, улс төрийн лидерд эрх баригчдад хир тустай ашигтай вэ? гэдэг нь шийдвэрлэх хүчин зүйл болно гэж үзсэн байна. Дээр нь хамтын ажиллагааны хүндрэлүүдийг тусгавал (Prisoners' Dilemma, Coordination Dilemma) байдал бүр ярвигтай болдог. Нийлүүлэлт талд нь бүс нутагт эдийн засгийн интеграцийг аваад явах хүсэл эрмэлзэлтэй маргашгүй лидер улс байх нь нэн чухал гэж тэр үзсэн байна. (Walter Mattli 1999).

БНХХ нь бүс нутгийн хэмжээнд илэрч буй глобальчлалын процесс гэж нэрлэж болох юм. Гэтэл буурай хөгжилтэй улс орнууд глобальчлалыг бололцоо гэхээсээ аюул гэж үзэх хандлага бас байгаа. Олон талт хэлэлцээрийн хүрээнд тариф буурч нөхцөл байдал сайжирч буй мэт харагдавч, тарифын бус арга, хөдөлмөр, байгаль орчны стандарт зэргээр жижиг орнуудыг хязгаарлах бололцоо ч бас байдаг.

II. ЗҮҮН ХОЙД АЗИ ДАХЬ УЛС ТӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ХАНДЛАГА

ЗХА-ийн салшгүй хэсэг болохынхоо хувьд энэ бүс нутаг дахь эдийн засгийн хамтын ажиллагааг Монгол улс сонирхож байна. Гэхдээ хамтын ажиллагаа нь голлон тоглогчдын улс төрийн тооцоо, Орос, Хятад, Япон болон АНУ-ын хоёр талын үйл ажиллагаагаар тодорхойлогдох юм.

А. ХОЁР ТАЛТ ХАРИЛЦАА

Орос-Хятад: Зөвлөлт холбоот улсын задралаас хойш ОХУ өөрийн шинэ байр суурь, үүрэг ролио хайж чиг хандлагаа эрэлхийлж байна. Европ түүнийг алга тосон угтана гэсэн найдлага үндсэндээ замхарч байна. Геополитик талаас болж өгвөл олон, болохгүй бол ямар ч болсон ганц туйлт биш дэлхий ертөнцийг ОХУ хүсэж байгаа юм. Нийгэм эдийн засгийн асар хүнд асуудлыг шийдэж буй ОХУ улс төр, эдийн засгийн шинэтгэлийн хэрэгсэл болгон интеграцийг чухалчлан ойлгож байна. Энэ үүднээс ч тэд ЗХА-д хандаж байна. Оросын алс дорнодын ирээдүйн талаархи санаа зовсон байдал, айдас нь ЗХА-ын талаар явуулах бодлогыг тодорхой хэмжээнд нөхцөлдүүлж байгаа нь ч ойлгомжтой. Нөгөө талаас хамгийн эрчимтэй хөгжиж буй эдийн засаг энэ бүсэд байгааг тооцоондоо авах ёстой. Тиймээс ч “ЗХА-д аюулгүй байдлыг хангах тогтолцооноос эдийн

засгийн хамтын ажиллагаанд тулгуурласан” системд шилжих нь зүйтэй гэж үздэг болж байна (Anna V.Shkuropat 2002).

Стратегийн хэд хэдэн хамтын сонирхолд тулгуурласан ОХУ, БНХАУ-ын харилцаа нь ойрын жилүүдэд улам ойртоно гэж судлаачид үзэж байна. “Олон туйлт дэлхий”-г дэмжих, аль нэгэн гүрэн дангаараа ноёрхох аливаа байдлаас сэрэмжлэхээ хоёр улс илэрхийлж байгаа. Гэхдээ Орос-Хятадын түншлэл нь Америкийн эсрэг эвсэл гэдгээс их хол бөгөөд барууны улсууд, АНУ зэрэг бусадтай хамтын ажиллагаа өргөжүүлэх бодлогод захирагдаж байгаа гэж зарим судлаачид үзэж байна. (Aleksander Lukin 2001).

Гадаад худалдааны хувьд жилийн өсөлт бараг 20 хувь болж 20 млрд ам.доллард хүрсэн хэдий ч Хятад-АНУ-ын 343 млрд ам.долларын худалдаатай харьцуулбал Орос Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа маш бага байгаа юм. Хятад зүүн хойд бүсээ эрчимтэй хөгжүүлэхийн тулд Оросын алс дорнодод хөрөнгө оруулалт хийх, хамтын ажиллагааны төслүүд хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа юм. Хятадууд алс дорнодод бөөнөөр суурьшиж байгаа нь Оросын хувьд “толгойн өвчин” болоод байгаа бөгөөд энэ асуудлаас үүдэн Оросын зарим судлаачид бүс нутгийн болон

хил хавийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудалд эргэлзэж байгаа юм.

Орос-Япон: ЗХА-ийн хамтын ажиллагааны асуудлыг Япон 1960-аад оны үед анх санаачилсан бөгөөд хоёр улсын харилцааг хэвийн болгох 1973 оны хэлэлцээр бүтэлгүйтсэнээс болоод Зүүн Өмнөд Ази руу анхаарлаа хандуулсан гэдэг. 1980-д оны төгсгөл асуудлыг дахин сөхөж эхэлсэн билээ. Япон далайн эрэг хавийн “мартагдсан бүс” тиймээс бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар эл нутгаа хөгжүүлэх чиглэл Япон баримталж эхэлсэн юм. Японы уламжлал, соёлын эх ЗХА-иас гаралтай гэж Япончууд үздэг (Gilbert Rozman 1999).

Түүхэн үүднээс авч үзвэл Оросын алс дорнодын түүхий эдийг ашиглах “цонхтой” болох нь Японы хувьд стратегийн бодлого байсан юм. Энэ утгаараа, Оростой, түүний эл бүстэй холбоотой удаан хугацааны эдийн засгийн харилцаа хөгжүүлэх нь Японы сонирхол юм. 90-ээд оноос хоёр улсын харилцаа нилээд прагматик шинжтэй болж эхэлсэн. Эл бүс нутагт байгалийн хий, нефть зэрэг түүхий эдийг ашиглах сонирхолтой байгаагаа Япон тод илэрхийлсэн юм. Жишээ нь, 5 млрд ам.долларын өртөг бүхий 4000

км урт хоолой Сибирээс Находка хүртэл татах төслийг Япон санал болгосон юм. Нефтийн хэрэгцээнийхээ 80 хувийг ойрхи дорнодоос татдаг Япон шинэ эх үүсвэр хайж байгаа бөгөөд эл утгаараа Орос, алс дорнод стратегийн хувьд ач холбогдолтой юм.

Хэдийгээр эдийн засгийн хамтын ажиллагааны асар их бололцоо байгаа ч эдийн засгийн харилцаа хамтын ажиллагаа удаан байна гэж шинжээчид үзэж байгаа юм. Үүний учир шалтгаан нь дэлхийн 2 дайн болон хүйтэн дайнаас үүдэлтэй юм. “Хойт нутгийн асуудал” гэгчийг Япончууд олон жил хөндөж байгаа ч шийдэл нь харагдахгүй л байна. Японы хувьд “хойт нутаг” гэдэг нь эдийн засгийн гэхээсээ илүү улс төрийн утга учиртай зүйл юм.

Хятад-Япон: Хятадын улс төрийн болон эдийн засгийн дипломат ажиллагаа ЗХА-д идэвхжиж байна. Тайваньд¹ цэрэг, улс төрийн дарамт шахалт үзүүлэхийн зэрэгцээ арилжааны нислэг зөвшөөрөх зэрэг арга замаар эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх бодлого Хятад барьж байгаа юм. Ямарваа хоёр улсыг нэгтгэх асуудлыг Хятад биш харин Тайвань өөрөө санаачлан тавих болно гэж зарим судлаачид үзэж байгаа юм.

¹ ЗХА-д заримдаа Зүүн Сибирь, Тайванийг багтаадаг.

9 сарын 11-ний дараа, аюулгүй байдлын бодлогодоо Япончууд тодорхой өөрчлөлтүүд тусгаж эхэллээ. Афганистан болон Иракт үйл ажиллагаа явуулж байгаа АНУ-ын зэвсэгт хүчинд ар талын хангалтын дэмжлэг үзүүлэх, Иракт /барилгын болон саперын/ цэргээ илгээх зэрэг үйлдэл нь анхаарал татаж байгаа юм. Энэ бол Японд төдийгүй бүс нутгийн хувьд аюулгүй байдлын шинэ нөхцөл байдал үүсгэж байгаа юм. Япончууд Үндсэн хуулиа шинээр тайлбарласан бөгөөд эл тайлбарын дагуу цэрэг дайчдаа дэлхийн аль ч өнцөгт илгээх бололцоотой болсноос гадна өөрийгөө хамгаалах хүчийг өмнө нь агентлагын хэмжээнд удирдаж байсан бол саяхнаас яамны статустай боллоо.

Энэ бүх үйлдлийг БНХАУ төдийгүй бүс нутгийн бусад улс орнууд анхааралтай ажиглаж байгаа юм.

БНХАУ супер гүрэн болон хувирч байгаа нь Японы хувьд олон талын дарамт учруулж байгаа юм. Жишээ нь, Зүүн Өмнөд Азийн орнуудтай ЧХГ байгуулах гэсэн Хятадын санал санаачлага Японыг сандруулсан. Тиймээс эл бүс нутагтай ЧХГ байгуулах асуудлыг яаравчлах, АСЕАН нэмэх нь 3 гэсэн хувилбар дээр ажиллахаас өөр сонголт Японд байсангүй.

АСЕАН-ын улсуудад ЧХГ санал болгохдоо Хятад тун өгөөмөр хандсан бөгөөд эл гэрээ нь зөвхөн бараа товар төдийгүй, үйлчилгээний

арилжаа, шууд хөрөнгө оруулалтын дүрэм журмыг хүртэл багтаахаар тусгасан юм.

Хятад улс ЧХГ байгуулах саналыг Японд тавьсан бөгөөд Японы тал “Хятад дөнгөж саяхан ДХБ-д элссэн” учраас арай болоогүй байна гэсэн байдлаар учирлаж байгаа ч үнэндээ өөрсдөө яах учраа олохгүй байгаа юм.

В. БҮС НУТГИЙН БАЙГУУЛААГУУД

ЗХА-ийг хамарсан бүс нутгийн гол байгууллага нь: АРФ, АПЕК, АСЕАН, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, Түмэн голын хөгжлийн хөтөлбөр юм.

АРФ (Asian Regional forum –гэдгийг ингэж тэмдэглэв) нь итгэлцлийг бэхжүүлэх, урьдчилан сэрэмжилсэн дипломат ажиллагаа, маргааныг шийдэх замаар аюулгүй байдлыг хангах чиглэл бүхий байгууллага билээ. БНАСАУ энэ байгууллагад 2000 онд нэгдэж орсноор ЗХА-ийн бүх улсыг багтаасан цорын ганц байгууллага юм.

Анхандаа нээлттэй худалдааг дэмжих зорилготой үүссэн АПЕК нь бүс нутгийн хэмжээнд дээд хэмжээний уулзалт зохион байгуулах, улс төр болон аюулгүй байдлын асуудлыг хэлэлцдэг байгууллага болсон. АПЕК-ын эдийн засгийн асуудал хариуцсан ажлын хэсэг нь санаачлагатай ажиллаж байгаа хэдий ч гишүүн орнуудын зүгээс илүү дэмжлэг шаардлагатай байгаа юм.

АСЕАН-тай хамтын ажиллагаа өргөжүүлэх чиглэлээр Хятад, Япон болон БНСУ нилээд

өрсөлдөж байгаа юм. Дээр дурьдсан, Хятад АСЕАН-тай чөлөөт худалдааны гэрээ байгуулсан, Япон энэ чиглэлээр ажиллаж байгаа ч тодорхой тохиролцоонд хүрээгүй байна. Харин БНСУ энэ байгууллагатай гурван жил хэлэлцээгээ үргэлжлүүлэн /Тайланд хараахан нэгдээгүй байгаа/ 2006 онд гэрээ байгуулсан.

Энэ бүгд нааштай хандлага хэдий ч түүхээс улбаатай үл итгэлцэл нь улс төр, аюулгүй байдлын талаас хүндрэл учруулж байгаа юм.

Анхандаа хилийн маргаан болон хил хавийн асуудал хэлэлцэх үүрэгтэй Шанхайн хамтын ажиллагааны байгууллага аажмаар цар хүрээгээ тэлж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, аюулгүй байдал, хил давуулан хар тамхи тээвэрлэх болон экстремизм, терроризмтэй тэмцэх асуудлыг хүртэл хамардаг боллоо.

ЗХА-д Засгийн газар хоорондын албан ёсны тогтсон бүтэцтэй байгууллага нь “Түмэн голын төсөл” юм. Уг төслийг анх Хятад хориод жилийн тэртээ санаачилсан бөгөөд Хятадын зүүн хойт хэсгийн хотууд, Хойт Солонгос, Алс дорнодын эдийн засгийн чөлөөт бүсүүдийг нэгтгэсэн “Олон улсын хот” байгуулахаар эхэлсэн билээ.

Алс дорнод болон Солонгосын хойгийн портуудад гарцтай болох үүднээс Монгол улс энэхүү санаачилгыг дэмжсэн юм. Энэ төслийн хүрээнд стратегийн ач холбогдол бүхий олон улсын “hub”

байгуулах, улмаар бүс нутгийн хамтын ажиллагаа болон аюулгүй байдлыг бэхжүүлэх бололцоотой гэж Монгол улс үздэг юм.

Хэдий “Түмэн голын төсөл” удааширч байгаа ч хилийн хавийн болон олон улсын ус, төмөр, засмал замын харилцаа, хөрөнгө оруулалтыг дэмжих, үйлчилгээ үзүүлэх байгаль орчны хамгаалал, аялал жуулчлал зэрэг сэдвээр сонирхолтой олон судалгаа хийсэн юм.

Бүсийн хүрээнд дэд бүсийн хөгжлийн асуудал бас давхар яригдаж байгаа юм. Тухайлбал, Шар далай хавийн эдийн засгийн бүс, Солонгос-Японы хоолойн бүс, Хойт-Өмнөд Солонгосын хамтын ажиллагааны бүс, Орос-Хятадын хил хавийн хамтын ажиллагаа, Монгол-Оросын хил хавийн чөлөөт эдийн засгийн бүс зэргийг нэрлэж болно.

ЗХА-ийн нэг гол субъект нь АНУ билээ. Энэ бүс нутагт өрнөж буй улс төр эдийн засгийн үйл явцыг АНУ туйлын анхааралтай ажиглаж байгаа юм. Бүс нутгийн тогтвортой олон талт хамтын ажиллагаанд Хятадыг байнга хамруулж байх сонирхол АНУ-д байгаа. Ингэснээрээ бүс нутгийн аюулгүй байдлыг хангах АНУ-ын ачаалал багасна гэж үзэж байгаа. Хүйтэн дайнаас үүдэлтэй үр дагаврыг даван туулахад Япон чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байгаа бөгөөд үүний тулд Япон илүү нээлттэй, илүү их итгэл даах хэмжээнд хүрэх ёстой гэж АНУ үздэг юм. Нөгөө талаас, АСЕАН + 3 зэрэг процессд Вашингтон

хоёрдмол байдлаар хандаж байгаа юм. Түүгээр ч зогсохгүй, Шанхайн байгууллагыг Америкийн эсрэг гэж эмзэглэж буй хандлага ч байна (Catharin Dalpino and Bates Gill, 2002, p20).

ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг улс төрийн хүчин тодорхойлдог гэж өмнө нь хэлсэн. 2001 оны 9-р сарын 11-ний дараа энэ бүс нутагт шинэ үзэгдлүүд ажиглагдах боллоо. Вашингтон, Москва, Бээжингийн хооронд улс төрийн шинэ харилцаа тэмдэглэгдэж байна. АНУ-ын Ерөнхийлөгч, эхлээд Хойт Солонгосыг “чөтгөрийн гурвалжин”-д багтааснаар байдал нилээд муудсан. Хойт Солонгос цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээнээс гарч, урьдчилсан цохилт хийхээр заналхийлж эхэлсэн. Хэдийгээр Хойт Солонгостой тодорхой хэлхээ холбоо, түүний удирдлагад гарцтай хэдий ч ОХУ болон Хятад нь түүний хүсээд байгаа хэмжээний эдийн засгийн болон технологийн туслалцаа үзүүлж чадахгүй юм. Өмнөд Солонгосын “нарны элч” бодлогоос тодорхой үр дүн гарсангүй. Хойт Солонгос үнэндээ АНУ-ыг л “хүлээн зөвшөөрч” байгаа юм. Тэд АНУ-гаас эдийн засгийн дэмжлэг салгаж авах хүсэлтэй байгаа бөгөөд ингэхдээ улс төрийн дотоод дэглэмдээ ямар нэгэн төвөг учруулахгүй байхыг хүсэж байгаа юм. Солонгосын хойгийн асуудлыг цэргийн хүчээр шийдвэрлэх аргагүй учраас гол тоглогчид

хамтран ажиллахаас өөр сонголт байхгүй. Тиймээс ч зургаан талын хэлэлцээ сэргэж тодорхой шийдэлд хүрч, ахиц дэвшил гарч байгаа нь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд ач холбогдлоо өгч байгаа билээ.

Бүс нутгийн аюулгүй байдлын асуудал нь олон хэмжүүрт үйл явдал юм. Тиймээс шийдэл нь ч гэсэн олон талт, цогц, нарийн байх ёстой (Amarjargal.R 2003).

Эдийн засгийн потенциал, өрнөж буй улс төрийн үйл явцаараа ЗХА дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг татаж байгаа. Нөгөө талаас, бүс нутгийн өмнө тулгамдаад буй асуудлууд, сорилтууд чухам юу билээ гэдгийг энэхүү тоглогч нар бас тод харж байгаа. Тиймээс улс төрийн шийдэлд хүрэхийн тулд эдийн засгийн хүчин зүйлсийг илүү их дайчлах ёстой.

Нээлттэй байдал болон глобальчлал тэлэх хирээр бүс нутгийн эдийн засгийн интеграци чамбайрдаг хандлага олон улсын туршлагаас ил харагдаж байгаа юм. ЗХА-д ч бас иймэрхүү хандлага ажиглагдаж байгаа юм. Гэхдээ бүс нутгийн эдийн засгийн потенциал болон асуудлын цар хүрээнд тохирсон хамтын ажиллагааны хэрэгслүүд үгүйлэгдэж байгаа нь илт билээ.

III. ЯПОН БА ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

А. БОДЛОГО ӨӨРЧЛӨГДСӨН НЬ

Их наймын дотроос чөлөөт худалдааны гэрээг хамгийн сүүлд хүлээн зөвшөөрсөн нь Япон билээ. Олон талт эдийн засгийн хамтын ажиллагаанаас хамгийн их хожсон улсын хувьд Япон чөлөөт худалдааны гэрээ нь “гишүүн бус орнуудыг ялгаварлан гадуурхсан элемент агуулдаг” учраас ГАТТ-ын үзэл санаанд нийцэхгүй гэсэн албан ёсны тайлбар хийдэг байсан юм. Гэсэн хэдий ч энэхүү тайлбар нь олон талт хамтын ажиллагааг Япончууд чухам яагаад ингэж их дэмжээд байгааг гүйцэд тайлбарлаж чадахгүй байгаа юмаа. Үүний цаана түүхэн болон улс төрийн сэдэл байгаа гэж үзүүлвэл үнэнд арай ойртох байх.

Кojima Akira-ийн (2001) үзэж байгаагаар “дэлхийн хоёрдугаар дайны дараа олон улсын хамтын нийгэмлэгт буцаж нэгдэх арга зам нь олон талт хамтын ажиллагаа байсан юм. Тийм ч учраас, ГАТТ\ДХБ болон НҮБ-аар дамжуулан олон талт хамтын ажиллагааг үлгэрлэн дэмжиж ирсэн бөгөөд ЧХГ байгуулахаас санаатай татгалзаж байсан”.

Тиймээс Япон олон арван жил эдийн засгийн биш харин улс төрийн учир шалтгааны үүднээс ЧХГ-д хандаж байсан гэж үзэж болно.

Харин 90-ээд оны төгсгөлд ЧХГ-ний талаархи байр суурь нь өөрчлөгдөж эхэлсэн юм. МIТI (2000) бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдийн тоо түргэн нэмэгдэж байгааг хүлээн зөвшөөрч, “ДХБ-ын олон талт худалдааны системийн дагалдах” элемент нь бүс нутгийн худалдааны хэлэлцээр болохыг тэмдэглэсэн юм. Японы байр суурь хэрхэн өөрчлөгдөж байсныг Японы гадаад яамны байр суурийн өөрчлөлтөөс үзэж болно (жишээ нь, Kojima Akira (2001), Naoko Munakata (2001), Tatsushi Ogita (2002)).

ЧХГ-ний талаар дуугардаг нэг гол төлөөлөгч нь Японы бизнесийн хүрээг төлөөлсөн Кейданрен юм. Түүний үзэж байгаагаар ЧХГ нь, “эдийн засгийн харилцааг улам бүр ойртуулж буй алхам юм”. Тухайн улстай худалдаа арилжааг өргөтгөх бололцоо, байгалийн баялаг (түүхий эд ба ажиллах хүч), яваандаа эдийн засгийн өсөлт авчрах бололцоотой эсэх, үйлдвэрлэл болон экспортын төв болох чадвар зэрэг шалгууруудыг ашиглан ЧХГ-г нягталж байхыг Кейданрен санал болгож байгаа юм. Хоёр улсын улс төрийн /түүх болон нийгмийн/ харилцаа, Японд хандах хандлага, хоёр улсын аж үйлдвэрийн бүтцийг харьцуулах зэргийг нэн чухал хүчин зүйлс гэж Японы бизнес

үздэг бөгөөд өрсөлдөөний тэгш нөхцөл олохыг эрмэлздэг юм. Тиймээс Кейданрен (1999) “тарифыг үе шаттай буулгах, хөрөнгө оруулалтанд учирч буй саад тотгорыг бүр мөсөн арилгах” эрмэлзэлтэйгээ мэдэгдсэн юм.

Японы байр суурь ингэтлээ өөрчлөгдсөний учир шалтгааныг дотоод гадаад орчинтой нь холбон ойлгоно. Гадаад хүчин зүйлс: ДХБ/ГАТТ хэлэлцээний хэд хэдэн үе шат бүтэлгүйтсэн, ДХБ-ын гэрээ хэлэлцээний механизм улам бүр нарийн төвөгтэй болж байгаа, олон талт хамтын ажиллагааны арга механизмд сэтгэл дундуур байгаа зэргийг нэрлэж болох юм. Энэ бүгдээс үүдэн бусад, юуны түрүүнд Японы өрсөлдөгч, улс орнууд төрөл бүрийн ЧХГ-ний гишүүн болсон юм. Түүнчлэн 90-ээд оноос эхлээд бүс нутгийн хамтын ажиллагааг эерэгээр үнэлдэг болсон юм. Нөхцөл байдал ингэж эргэж байхад Япон хөдлөхгүй байх нь изоляци-д хүргэх магадлалтай. Харин изоляцийн улс төрийн болон эдийн засгийн үнэ өртгийг Япон дийлэхгүй гэдэг нь ойлгомжтой болсон юм.

Ази тив дэх хөгжлийн чиг хандлагыг Азийн эдийн засгийн хямрал сүрхий өөрчилсөн юм. Японы хөгжлийн загвар бусдыг татах, бусдад үлгэрлэл болох чадвараа алдаж эхэлсэн юм. Хятад “супер гүрэн” болж босож байгаа, Хятад төвтэй эдийн засгийн хөгжлийн хандлага бий болж байгаа, Японы оролцоогүй эдийн засгийн эвсэл бие дааж бүрдэх зэрэг чиг хандлагууд Японыг сандраасан л даа.

Япон дотоод хөшмөл улс төр болон эдийн засгийн бүтцээ өөрчлөх, илүү нээлттэй, уян хатан болж чадахгүй бол Азид өмнө нь гүйцэтгэж байсан үүрэг, нэр нөлөөгөө хадгалж чадахгүй нь ойлгомжтой. Япон өөрчлөгдөж байж л Азийн улс орнуудын итгэлийг олж авах бөгөөд энэ замаар л бүс нутгийн болон тив дэлхийн аюулгүй байдалд хувь нэмрээ оруулна (Kojima Akira 2001, Urata Shujiro 2003, Hatakeyama Noboru 2003).

Дотоод хүчин зүйлсийн хувьд дараах хэдийг нэрлэж болох юм. Олон улсын хамтын ажиллагааг ашиглах: дотооддоо бүтцийн өөрчлөлтийг түлхэх үүднээс “түншийн шахалтыг” ашиглах бололцоог ЧХГ олгоно. Олон улсын гадаад худалдааны талаарх Олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яамны 2000 оны цагаан номонд ЧХГ-ний “бодлогын шинэтгэлийн үр дагавар нь” их нааштай гэдгийг тэмдэглэсэн байдаг.

Японы эдийн засгийн өрсөлдөх чадварын өөрчлөлт

	<i>Хүснэгт 2</i>		
	1980	1990	2000
Нэгдсэн дүн	4	3	16
Гадаад зах зээл	11	11	17
Санхүүгийн сектор	3	3	21
Корпорацийн сектор	2	3	13
Боловсрол	10	4	7
Дэд бүтэц	12	12	10
ШУ ба технологи	2	2	2
Мэдээллийн технологи	-	-	14

Уг сурвалж: Urata Shujiro (2003)

Дотооддоо эдийн засгийн хүрээнд өргөн цар хүрээтэй шинэтгэл хийх зорилттой Япон учирсан юм. Японы эдийн засаг 90 оны эхнээс бараг арав гаруй жил стагнацийн байдалд байсан. Тухайлбал, чанаргүй зээлд суурилсан банкны системн хямрал, дефляци, эдийн засгийн хэт зохицуулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс хорогдсон байдал, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа алдаж эхэлсэн г.м маш олон асуудал нүүрлэсэн юм. Үндсэндээ 90-ээд оноос эхлэн Япон эдийн засгийн хөгжлийн динамикаа алдсан гэж Urata Shujiro (2003) үзжээ. Японы өрсөлдөх чадварын нийлбэр үзүүлэлт 1980, 1990 онд дөрөв, гуравдугаар байранд байсан бол 2000 он гэхэд 16 байранд хүртлээ унасан юм (Хүснэгт 2).

Түүнээс гадна изоляцид орохын хохирлыг Японы компаниуд шууд мэдэрч эхэлсэн гэж Hatakeyama Noboru (2003) болон Keidanren (1999) тэмдэглэсэн байдаг. Жишээ нь, НАФТА-ын ачаар Америкийн компаниуд Мексик рүү татваргүй бараа экспортлож, түүнчлэн ЕХ-Мексикийн ЧХГ-ний дагуу Европын Холбооны улсууд чөлөөтэй экспортлож байсан бол Японы компаниуд гаалийн татвар төлөх ёстой байдаг. Howard J.Wall (2002)-ийн судалгаагаар 1994 оноос эхлэн НАФТА-тай, 1992 оноос эхлэн ЕХ-той хийж буй худалдааны хувийн жин тус тус буурч эхэлсэн юм.

Бас нэг хүчин зүйлийг нэрлэх ёстой. Эдийн засгаа либералчлахыг АНУ нилээд шахаж байсан нь “их гүрний дээрэнгүй тулгалт”

гэж олонхи Япончууд үзэж, Америкийн эсрэг үзлийг сэргээж, энэ нь улмаар ЧХГ байгуулахад түлхэц болсон гэж Kojima Akira (2001) дүгнэсэн байх юм.

Б. ЧХГ-НИЙ ЯВЦ

Дотоод гадаад хүчин зүйлсийн харилцан үйлчлэл, өөрчлөлтийн үр дүнд ЧХГ-нд хандах Японы байр суурь өөрчлөгджээ. Тус улсад ЧХГ-г дэлгэрүүлэхэд Ерөнхий сайд асан Обучи чухал үүрэг гүйцэтгэсэн гэж Naoko Mi-nakata (2001) үзжээ. Гэхдээ асуудлыг анхлан Мексик 1998 онд хөндсөн гэж Hatakeyama Noboru (2002) бичсэн байна. Ямар ч болсон Мексикийн дараа ЧХГ байгуулах саналыг Өмнөд Солонгос тавьсан бөгөөд харин Сингапуртай анхны гэрээгээ байгуулсан юм. Эндээс үзэхэд, чухам хэнтэй гэрээ байгуулах вэ гэдэг асуудалд улс төрийн өнцгөөс хандаж хамгийн “гай багатай” Сингапуртай гэрээ байгуулахаар Япон шийдсэн нь тодорхой байгаа юм.

Мексик, Чили, Өмнөд Солонгос, Бразил, Австрали, Канада, Шинэ Зеланд, Тайланд, Тайвантай чөлөөт худалдааны асуудлаар гэрээ хэлэлцээр хийж эхэлсэн бөгөөд БНСУ, АСЕАН-тай аль болох хурдан гэрээ байгуулах байр суурьтай байлаа.

Хоёр талын хэлэлцээр гэрээ талаасаа АНУ-тай хийж байгаа хэлэлцээр хамгийн хэцүү юм. Японы зах зээлд ХАА-н бутээгдэхүүн

нийлүүлэгч тэргүүлэгч нь АНУ билээ. Нөгөө талаас Японы аж үйлдвэрийн бүтээгдэхүүн ямар нэгэн татваргүй АНУ-ын зах зээлд орж ирэхээс Америкийн тал бас айж байгаа. Тиймээс эхний ээлжинд үйлчилгээний салбарт хамтран чөлөөтэй худалдаа хийх саналыг хамгийн боломжтой гэж Hatakeyama Noboru (2002) үзэж байна.

ЧХГ байгуулах шалгуур, цар хүрээний хувьд хамгийн гол нь эдийн засгийн ач холбогдол гэж Японы гадаад яам үзэж байгаа юм (MoFA 2002). Гэхдээ ЧХГ-ний “тодорхой агуулга, шинж чанараас” түүний үр ашиг нь нэн түрүүнд хамаарна. (Christopher Edmons and Jean-Pierre Verbiest 2002). ЧХГ нь нарийвчлан үзвэл эдийн засгийн гэхээсээ илүү улс төрийн феномен учраас зөвхөн эдийн засгийн үр ашгаар асуудлыг хязгаарлаж болохгүй юм. Тухайлбал, ЧХГ нь эдийн засгийн интеграцийг өргөжүүлэх, буурай хөгжилтэй улс орнуудтай эдийн засгийн түншлэлээ бэхжүүлэх хэрэгсэл гэдгийг анхаарах ёстой юм. ЧХГ-ний эдгээр талууд нь бүс нутагтаа манлайлах сонирхолтой Японы хувьд чухал билээ. Тиймээс ЧХГ нь зөвхөн гадаад худалдаа болон ГШХО-ийг либералчлах асуудлыг хөндөхөөс гадна эдийн засгийн болон техникийн туслалцааг бас тусгах ёстой гэж Urata Shujigo (2003) тэмдэглэсэн байна.

ЧХГ нь статик үр дагавраас гадна, худалдааны саад хоригийг арилгах, дотоод зах зээл дэх өрсөлдөөнийг чанаржуулах, хөдөлмөрийн

бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг динамик эффект агуулж, түүнийг Японы тал илүү сонирхож байгаа юм.

Японы эдийн засгийн бүтэц, үйл ажиллагаа явуулдаг институтуудыг анхааралдаа авбал ЧХГ-г сурталчлах, хэрэгжүүлнэ гэдэг нь амаргүй. Японы эдийн засгийн бүтэц нь тэр чигээрээ шууд болон шууд бус татаас, тусгай хамгаалалт, дэмжлэг дээр тулгуурласан байдаг юм. Ялангуяа, “мэдрэмжтэй” салбаруудад байдал тун хэцүү бөгөөд ЧХГ байгуулсан нөхцөлд энэ бүгдээс ямар нэгэн байдлаар татгалзах, багасгах, бууруулах болно.

В. ЯПОН СИНГАПУРЫН ЧХГ /ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ/

ЯСЭЗТГ нь жирийн ЧХГ-тэй харьцуулшгүй өргөн агуулгатай юм.

Юуны өмнө яагаад Сингапурыг сонгов гэдэг асуулт гарч байгаа юм. Сингапурын экспортолж болох бараг бүх зүйл Японд байгаа бөгөөд импортынх нь хэрэгцээг Япон хангах чадавхитай учраас “санаа зовох зүйлгүй” байсан гэж Ramkishan S.et al. (2002) нар үзжээ. ЧХГ-ний хувьд хамгийн гол нь эдийн засгийн үр ашиг гэж Япон хэдий зарлаж байсан ч үнэндээ улс төрийн үүднээс асуудалд хандсан нь тодорхой байгаа юм. Япончуудын “мэдрэмжтэй” салбар болох газар тариалан, загасны аж ахуйн асуудал хоёр улсын хооронд байхгүй учраас Сингапуртай анхлан гэрээ байгуулсан учиртай гэж дүгнэж болох юм. Хамгийн сонирхолтой нь

энэхүү “мэдрэмжтэй” гээд байгаа салбарууд нь Японы эдийн засагт тун өчүүхэн хувь эзэлдэг бөгөөд эдийн засгийн хувьд бараг мэдрэгдэхгүй мөртлөө улс төрийн хувьд нэн чухал салбарууд юм.

Улс төрийн бас нэг чухал хүчин зүйлс нь ажиллах хүчний миграци. Өндөр хөгжилтэй бусад орнуудтай харьцуулбал, ажиллах хүчний хөдөлгөөн буюу ер нь жирийн хүмүүсийн хөдөлгөөнийг Япон хэтэрхий хатуу хязгаарласан байдаг. Энэхүү гэрээний дагуу Сингапурчууд Японд очих бололцоо нилээд нээгдсэн бөгөөд бид “маш том буулт хийлээ” гэж Япончууд тайлбарлаж байгаа юм. Үнэндээ Сингапурчууд бүгдээрээ Японд очоод суурьшина гэж бараг байхгүй зүйл л дээ. Мөн харилцан мэргэжлийн диплом, ур чадварыг хүлээн зөвшөөрсөн заалт багтсан юм.

ЧХГ-ний асуудлаар Японы байр суурь өөрчлөгдсөн учраас дараа дараагийн түншүүдтэй гэрээ хэлэлцээр хийнэ. Тиймээс анхны гэрээ заавал амжилттай болох ёстой гэсэн Японы байр суурь, эдийн засгийн бүтэц харилцан тохирч байгаа зэрэг нь шийдвэр гаргахад нөлөөлсөн юм. ЯСЭЗТГ нь цаашдын гэрээний үлгэр загвар нь болно гэж Япончууд үздэг.

Товчоор, амьжиргааны түвшин ойролцоо, газар зүйн хувьд ойр, эдийн засгийн хувьд харилцан ашигтай гэх мэтийн үндэслэлүүд нь улс төрийн учир шалтгааны дайвар хүчин зүйлс байсан юм.

Сингапурын тал ч бас улс төрийн үүднээс шийдвэр гаргасан гэдгээ хүлээн зөвшөөрдөг. Жижиг хот улс олон улсын анхаарал татах, нэр хүндээ өсгөх, улс төрийн хувьд хүлээн зөвшөөрөгдөх, улмаар бүс нутгийн болон олон талт худалдааг дэмжих үүднээс гэрээ байгуулснаа Tommy Koh (2000) илэрхийлсэн байдаг.

ЯСЭЗТГ-ний явц

- 1999 оны 12 сар: Сингапурын ерөнхий сайд Японд айлчилсан;
- 2000 оны 3 сарын 7-8: ЯСЭЗТГ судлах ажлын хэсгийн анхны уулзалт;
- 2000 оны 9 сар: илтгэл бэлэн болсон;
- 2000 оны 10 сар: хэлэлцээр эхэлсэн;
- 2002 оны 1 сарын 13: гэрээнд гарын үсэг зурсан;
- 2002 оны 5 сарын 8: гэрээг Японы парламент соёрхон баталсан;
- 2002 оны 10 сарын 30: ЯСЭЗТГ талаар нот бичиг солилцсон;
- 2002 оны 11 сарын 30: хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

ЯСЭЗТГ-ний хувьд гэвэл энгийн ЧХГ-нд тусгагддаг стандарт зүйлсээс гадна бас шинэ элементүүд орсон юм. Тухайлбал, “цаасгүй арилжаа” хангах дэд бүтцийг бүрдүүлэх, мэргэжлийн хяналтын дүгнэлтийг харилцан хүлээн зөвшөөрөх, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн хамтарсан зөвлөл байгуулах, Гинза болон Очард роуд зэрэг алдартай

худалдааны гудамжийг “ихэрлэх”, Мэдээлэл Харилцаа Холбооны Технологийн арилжаанд техникийн болон технологийн ямар нэгэн саад учруулахгүй байх, е-арилжааг бүх талаар дэмжих, өргөн зурваст сүлжээ, санхүүгийн үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжих, иргэдийн шилжилт хөдөлгөөн зэрэг олон асуудлыг знэхүү гэрээнд тусгасан юм.

ЯСЭЗТГ нь а. Өрсөлдөөний бодлогоо уялдуулан хамтран ажиллах, б. Төрийн нэрийн өмнөөс бараа ажил үйлчилгээ худалдан авах тогтолцоог журамлах, в. Оюуны өмчийн талаар хамтран ажиллах нэгдсэн бодлого явуулах, г. Шинжлэх ухаан технологи болон боловсон хүчин бэлтгэх чиглэлээр хамтран ажиллах, д. Маргаан шийдвэрлэх тогтолцоо

бүрдүүлэх эхлэлийг тус тус тавьсан юм.

Ерөнхийдөө, хоёр улсын худалдааны арилжааны өртгийг бууруулсанаараа ЯСЭЗТГ нь эдийн засгийн мэдэгдэхүйц хожоо авчирч байгаа юм.

ЯСЭЗТГ хэр нээлтгэй вэ гэдэгт хоёр тал хэрхэн хандаж байгаа нь сонирхолтой юм. Хоёр талын улс төрчид энэхүү гэрээ нь “үзэл санаа нэгт” улс орнуудад нээлттэй, өөрөөр хэлбэл, бусад орнууд гэрээнд нэгдэж болохоор зарлаж байсан ч (Bussines Times, Singapore, December 5, 2000) үнэндээ бол Японы Ерөнхий сайд Коизуми шинээр аль нэгэн улс нэгдэх ямар ч бололцоогүй гэсэн юм. (Low, 2002)

IV. ЧХГ: МОНГОЛЫН ГАДААД ХУДАЛДААНД ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨ

А. ЗАГВАР

Монголын гадаад худалдаа ЧХГ байгуулсан нөхцөлд хэрхэн өөрчлөгдөхийг судлах үүднээс гравитацийн загварыг ашиглаж байгаа юм. Энэхүү загвар нь энгийн бөгөөд “урьдчилан хэлэх” чадвар нь өндөр учраас эдийн засагчид өргөн ашигладаг юм. Түүгээр ч үл барам зарим өгөгдөхүүн шинээр тусгах бололцоо олгодог учраас ашиглаж буй загварыг уян хатан болгодог сайн талтай.

Макро-эконометриksын хувьд нэгэн зэрэг хазайлтын асуудал шийдлээ бүрэн олоогүй бөгөөд тиймээс, үнэхээр экзоген болоод гадаад худалдаатай нягт уялдаатай тийм хувьсагч олох нь нэн чухал байгаа юм (Jeffrey A. Frankel. 1996a, p4).

Гравитацийн загварын санаа нь туйлын энгийн бөгөөд хоёр улсын хоорондын худалдаа нь тухайн улсуудын эдийн засгийн хэмжээтэй нь шууд, хоорондын зайтай нь урвуу хамааралтай гэсэн үндэслэлд тулгуурладаг.

$$T_{ij} = f(Y_i, Y_j, D_{ij}) \quad (1)$$

Гадаад худалдааны урсгалыг таамаглах чадвар гравитацийн загварын хувьд үнэхээр сайн юм гэдгийг эдийн засгийн судалгаанууд тодорхой харуулж байгаа юм. Jeffrey A. Frankel.(1996a, p4)

болон бусад судлаачид уг загварын онолын үндэслэл эрс сайжирсныг тэмдэглэж байгаа бөгөөд нөгөө талаас эдийн засгийн хувьд газар зүйн байршил болон биет хүчин зүйлсийн нөлөөллийг эдийн засагчид сүүлийн үед ихээхэн анхаарч байгаа.

Гравитацийн загварыг Монголын хувьд ашиглаж байгаа нь шинэ зүйл.

Судлаачдын үзэж байгаагаар энэхүү загварыг 2003 оноос өмнө ашиглаж байсан судалгаа байхгүй юм. Далайд гарцгүй, алслагдсан, худалдааны түншүүдийн эдийн засгийн хэмжээ эрс ялгаатай зэрэг хүчин зүйлс нь гравитаци загварын бололцоог бүрэн үзүүлнэ гэж хүлээж байна.

Дээрхи (1) загварт тулгуурлан энэ судалгаанд зориулан боловсруулсан загвар нь доорхи хэлбэртэй:

$$T_{wm} = \alpha + \beta Y_w + \gamma Y_m - \delta D_{wm} + e \quad (2)$$

Энд, T_{wm} тухайн улстай хийж буй Монголын экспорт, импорт, Y_w , Y_m - m болон w улсын ДНБ, D_{wm} - m болон w улсуудын хоорондын зай, and e - алдаа.

Энд хамгийн бага квадратын (OLS) аргаар тооцоо хийсэн бөгөөд R^2 нь хангалттай байж, зайн урвуу хамаарал нь тод харагдана гэж үзэж байна.

В. ӨГӨГДӨЛ

Тэгшитгэл (2)-ыг тооцохдоо АХБ гаргасан хоёр талын худалдааны мэдээ (Key Indicators 2001: Growth and Asia and the Pacific) худалдааны түншийн ДНБ-ий тухай мэдээг IFS-ийн статистик мэдээнээс авсан бөгөөд <http://www.indo.com/index.html> -ээс улс хоорондын зайг авсан юм. Бүхэлдээ 1984-2001 онуудыг хамруулсан болно.

Хоёр талын худалдааг мянган, ДНБ-ий сая ам. долларт хөрвүүлсэн. Монголын гадаад худалдаанд Хятад, АНУ, Орос /ЗХУ/, БНСУ, Япон, Их Британи, Герман хамтдаа 82.8 хувь болж байгаа юм. Нэгэн сонирхолтой зүйл нь Монгол улс голдуу өндөр хөгжилтэй улс орнуудтай арилжаа хийдэг бөгөөд хөгжиж буй орнуудын хувийн жин тун бага юм. Бас нэг зүйлийг зайлшгүй дурьдах ёстой. 90 оноос өмнө Монголын гадаад худалдаа нь үндсэндээ Европ руу, СЭВ-ын гишүүн орнууд руу чиглэсэн байсан бөгөөд ЗХУ маргашгүй доминант байсан юм /График 2/.

Хоёр талын худалдааны судалгаанд голдуу нэг хүнд ноогдох орлогыг ашигладаг. Харин энэ судалгаанд ДНБ-ийг ашиглан тухайн оны ханшаар тооцсон юм. Учир нь, гадаад худалдаа нь үндсэндээ дэлхийн зах зээлийн үнээр хийгддэг учраас нэг хүнд ноогдох ДНБ эсвэл худалдан авах чадварын паритет нь яг худалдааны хэмжээнд хүчтэй нөлөөлөхгүй гэж

үзсэн. Нөгөө талаас, Монгол шиг жижиг эдийн засгийн хувьд худалдааны түншүүдийн ДНБ нь экзоген үзүүлэлт юм (Jeffrey A.Frankel. 1996a, p5).

IFS мэдээнд Оросын ДНБ-ий талаар зарим өгөгдөхүүн дутуу байсан юм. Тиймээс, ЗХУ-ын цэвэр материаллаг бүтээгдэхүүн гэсэн үзүүлэлтийг албан ёсны 0.60 рубль/ам.доллар гэсэн ханшийг ашиглан ДНБ-д хөрвүүлсэн Kuboniwa, Masaaki (1997)- ийн хийсэн судалгаанаас мэдээг нөхөж оруулсан болно. Зарим нэгэн судлаач энэхүү аргачлалыг шүүмжилж магадгүй, гэхдээ ЗХУ болон БНМАУ-ын эдийн засгийн зөрүү нь тухайн үедээ дэндүү их байсан учраас хялбарчлах үүднээс зарим нэгэн тоон үзүүлэлтийн хэлбэлзлийг орхигдуулж болно гэж үзсэн юм.

Зайн хувьд Улаанбаатар хотоос тухайн улсын нийслэл хүртэлх зайг авсан юм. Энэ аргачлалыг бас шүүмжилж болох боловч хил залгаа Хятад Оросын хувьд нарийвчлал чухал болохоос бусдад нь нэг их хамааралтай зүйл биш гэж үзсэн юм. Хэдий хил худалдаа өргөжиж байгаа ч түүхэн үүднээс үзвэл Монголын экспорт импорт нь ЗХУ-ын Уралын цааших Европ хавьд илүү ноогдож байсан юм. БНХАУ-тай бас нэг иймэрхүү дүр төрх байсан.

Бүх өгөгдөхүүнийг натураль логарифмын \ln функци болгон 1984-2001 онуудыг ажиглалтын болгон авсан юм.

С. ИМПЕРИК ҮР ДҮН

Тэгшитгэл (2)-ын функц хэлбэр нь дараах байдалтай болно.

$$\ln T_{wm} = \alpha + \beta \ln Y_w + \gamma \ln Y_m + \delta \ln D_{wm} + e \quad (3)$$

Судалгааны дүнг доорхи хүснэгтэд тусгасан байгаа (Хүснэгт: OSL дүн).

Тооцооноос үзэхэд бүх өгөгдөхүүнүүд хүлээж байсан хамааралтай гарсан бөгөөд статистикийн хувьд нөлөөлөлтөй нь тодорхой байна. Зай нь маш хүчтэй нөлөөтөй, урвуу хамааралтай бөгөөд энэ хүчин зүйлээс хамааран бололцооноосоо гадаад худалдааны эргэлт хоёр дахин бага гэсэн тооцоо гарчээ.

Гэхдээ R_2 нь тооцож байснаас бага (0.186) гарсан юм. Тэгэхлээр нь Монголын худалдааны байдлыг тайлбарлаж чадах бусад хувьсагчдыг судалж эхэлсэн. Өмнө нь дурьдаж байсанчлан 90 оноос эхлэн Монгол улс асар том өөрчлөлтөд өртөж байгаа билээ. Тиймээс, тэгшитгэл (3)-д REFORM гэсэн дамми хувьсагч оруулж 1984-1990 онуудад нэг, түүнээс хойш онуудад тэг гэсэн утга өгсөн юм. 1990 оноос хойш эдийн засаг нээлттэй болж худалдааны үзүүлэлтүүд сайжирна гэж үзээд ингэснээр урвуу хамаарал зайлшгүй байх ёстой гэж тооцсон юм. Үнэхээр ч шинэтгэлийн өмнөх жилүүдийн худалдааны үзүүлэлт нь дараах онуудаас 1.48 пунктээр доогуур байсан юм.

Монголын далайд гарцгүй байдал нь гадаад худалдаанд сөргөөр нөлөөлнө гэж тооцон энэ

байдлыг илэрхийлсэн бас нэгэн Border гэсэн дамми өгөгдөхүүн нэмж оруулсан бөгөөд ОХУ, БНХАУ-д нэг, бусдад нь тэг гэсэн утга өгсөн юм. Эндээс хил залгаа улстай хийж байгаа худалдааны хэмжээ бусдаас 2.15 пункт илүү байгаа нь илт байна.

Социализмын он жилүүдэд ЗХУ-аас хэтэрхий хараат байсан монгол гадаад худалдаагаа диверсификаци хийх гэж оролдож байгаа нь ойлгомжтой. Тиймээс Монголын гадаад худалдааны чиглэл, урсгал эрс өөрчлөгдсөн юм. Нөгөө талаас оросын Алс дорнод, Сибирь, түргэн хөгжиж буй Хятадын зүүн хойт хэсэг бас боломж бүрдүүлж байгаа юм.

Тиймээс бас нэг дамми үзүүлэлт буюу Японтой ЧХГ байгуулсан нөхцөлд мөн Зүүн Хойт Азид эдийн засгийн интеграци бүрдэж түүнд нь Монгол улс нэгдвэл ямархүү дүр төрх үүсэхийг гипотетик маягаар тодорхойлох гэж оролдсон юм. Бидний тооцоогоор хэрвээ Японтой ЧХГ байгуулбал гадаад худалдаа бараг тавин хувь нэмэгдэх бөгөөд Зүүн Хойт Азийн интеграцид нэгдвэл статистикийн хамаарал багатай гэсэн дүн гарсан юм. Сүүлчийн тохиолдолд худалдаа өргөжүүлэх эффект ямар ч нөхцөлд байгаа гэдэг нь ойлгомжтой.

Хамгийн сүүлийн хувилбараар сөрөг үр дагавар бараг 20 хувиар буурч байгаа юм. Тиймээс, газар зүйн хувьд алслагдсан байдлын сөрөг үр дагаварыг туулахын тулд гадаад худалдааны нээлттэй бодлого, түүний дотор шинэ түнштэй ЧХГ байгуулах чиглэлээр Монгол ажиллах ёстой юм.

ТӨГСГӨЛ

Монгол шиг жижиг орнууд харьцангуй давуу талаа тодорхойлохдоо сүүлийн үед өргөн дэлгэрч буй бүс нутгийн болон хоёр талын чөлөөт худалдааны гэрээний бололцоог ашиглах ёстой юм. Дотоодын эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдэх, шинэтгэлийн процессыг хэрэгжүүлэхдээ дэлхийн эдийн засгийн интеграцид хамрагдах замыг Монгол ашиглах ёстой. Энэ бодлогын хүрээнд Зүүн Хойт Ази дахь эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх сонирхол Монголд байгаа юм. Гэхдээ энэ бүс нутгийн хамтын ажиллагааг эдийн засгийн гэхээсээ илүү тодорхой түүхэн болон бусад учир шалтгааны улмаас улс төрийн хүчин зүйлс тодорхойлж


байна. Гравитаци загвар ашиглан газар зүйн хүчин зүйлсийг анхааралдаа авч болох гипотез маягийн ЧХГ-нд нэгдсэн нөхцөлд Монголын гадаа худалдаа хэрхэн өрнөж болохыг энэ судалгаанд харуулсан юм. Судалгаанаас үзэхэд гадаад худалдааны нээлттэй бодлого явуулах, аль болохоор бүс нутгийн интеграцид нэгдэх, хоёр талын худалдааны гэрээ байгуулах замаар алслагдсан байдал, түүнээс үүдэж буй сөрөг үр дагаварыг Монгол давж чадна.

АНУ болон Европын Холбооны Улсад татваргүйгээр экспортлож болох бараа бүтээгдэхүүний жагсаалт болон түүнтэй холбоотой дүрэм, журмыг www.forum.mn сайтаас олж харна уу?


Table: OLS Results Dependent Variable: Mongolia trade

	Intercept	GDP	GDP	DISTANCE	REFORM	BORDER	JAPAN	NEA
Coefficients	6.079	0.260	0.175	-0.977				
Standard Error	1.201	0.061	0.060	0.133				
t Stat	5.063	4.236	2.946	-7.334				
Coefficients	3.150	0.425	0.344	-1.010	-1.484			
Standard Error	1.133	0.058	0.057	0.120	0.172			
t Stat	2.781	7.268	6.029	-8.421	-8.630			
Coefficients	1.058	0.451	0.369	-0.255	-1.695	2.149		
Standard Error	0.961	0.049	0.048	0.119	0.144	0.183		
t Stat	1.101	9.249	7.761	-2.143	-11.732	11.768		
Coefficients	1.360	0.431	0.350	-0.213	-1.651	2.197	0.503	
Standard Error	0.983	0.051	0.049	0.122	0.148	0.186	0.358	
t Stat	1.384	8.498	7.073	-1.739	-11.193	11.842	1.406	
Coefficients	1.394	0.430	0.349	-0.200	-1.676	2.187	0.439	0.239
Standard Error	0.987	0.051	0.050	0.126	0.158	0.187	0.367	0.309
t Stat	1.412	8.446	7.034	-1.588	-10.634	11.697	1.196	0.772
R Square				0.186	0.343	0.545	0.548	0.548
Observations				318.000	318.000	318.000	318.000	318.000


Зураг 1. Монгол ҮНБ, 1984-2001



Зураг 2. Худалдааны гол түншүүд, хувь 1984-2001



Зураг 3 Монгол: Гадаад худалдааны динамик, сая USD



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. About JSEPA see <http://www.mofa.go.jp/region/asia-paci/singapore/jsepa.html>
2. ADB (2002) Key Indicators 2001: Growth and Change in Asia and the Pacific retrieved on December 27, 2002 from http://www.adb.org/Documents/Books/Key_Indicators/2001/mon_ki2001.xls
3. Alexander Lukin (2001) "Russia's Image of China and Russian-Chinese Relations," CNAPS Working Paper, May 2001
4. Anna Shkuropat(2002), "New Dynamics in Northeast Asia: The Russian Factor" CNAPS Working Paper, July 2002
5. Asian Development Bank (2002), The Asian Development Outlook 2002.
6. Baldwin, Robert E (2002) "Openness and Growth: What's the Empirical Relationship?" the paper presented at the International Seminar on International Trade (ISIT): Challenges to Globalization, A CEPR/NBER/SNS conference, May 24-25, 2002, Stockholm, Sweden. Retrieved: January 30, 2003, from <http://www.cepr.org/meets/wkcn/2/2316/papers/baldwin.pdf>
7. Bhagwati Jagdish ed., (2002) "Going Alone. The Case for Relaxed Reciprocity in Freeing Trade" MIT Press, London.
8. Boone, Peter (1994), "Grassroots Macroeconomic Reform in Mongolia" *Journal of Comparative Economics* 18, 314-328
9. Catharin Dalpino and Bates Gill (2002), "Brookings NorthEast Asia Survey 2001-02", Center for NorthEast Asian Policy Studies, The Brookings Institutions. Retrieved: on February 20, 2003, from <http://www.brookings.org/dybdcrooft/fp/cnaps/papers/survey02.htm>
10. Christopher Edmons and Jean-Pierre Verbiest (2002) "The Role of Preferential Trading Arrangements in Asia", ERD Policy Brief No.8
11. de Melo, Martha, Cevdet Denizer, Alan Gelb, and Stoyan Tenev. 2001. "Circumstances and Choice: The Role of Initial Conditions and Policies in Transition Economies." *World Bank Economic Review* 15(1): 1-31.
12. Distance data retrieved from <http://www.indo.com/index.html>
13. Emiko Fukase And L.Alan Winters (1999) "Possible Dynamic Benefits of ASEAN/AFTA Accession for the New Member Countries" World Bank, Washington, D.C
14. Gerard Roland (2001) The Political economy of transition" WDI Working Paper 413
15. Gilbert Rozman (1999), "Backdoor Japan: The Search For A Way Out Via Regionalism And Decentralization". *Journal of Japanese Studies* 25:1 1999
16. Grossman, G.M.; Helpman, E, (1990) "Comparative advantage and long-run growth" *American Economic Review*, Vol. 80 Issue 4, p796-815

17. Hahm, Hongjoo (1993) "The Development of the Private Sector in a Small Economy in Transition: The Case of Mongolia" World Bank Discussion Paper No.223, Washington, DC.
18. Hatakeyama Noboru (2003) "Short History Of Japan's Movement To Ftas" Journal Of Japanese Trade And Industry Nov/Dec 2002 -Jan/Feb 2003
19. Howard J. Wall (2002), "Has Japan been Left Out in the Cold by regional Integration?" The Federal Reserve Bank of St. Louis
20. Jeffrey A. Frankel, David Romer (1999), "Does Trade Cause Growth?" American Economic Review 89, no. 3, June 1999, 379-399.
21. Jeffrey A. Frankel, David Romer and Teresa Cyrus (1996a) "Trade and Growth in East Asian Countries: Cause and Effect?" NBER Working Paper No. 5732, August 1996.
22. Jeffrey Sachs, Wing Thye Woo And Xiaokai Yang, (2000) "Economic Reforms And Constitutional Transition", Annals of Economics and Finance, 1,423-479.
23. Keidanren (1999), "Report on the Possible Effects of a Japan-Mexico Free Trade Agreement on Japanese Industry" Working Group on Japan-Mexico Bilateral Treaties Japan-Mexico Economic Committee, from <http://www.keidanren.or.jp/english/policy/pol099.html>
24. Kojima Akira (2001) "Free Trade Agreements As Constructive Regionalism" Journal Of Japanese Trade And Industry January/February 2001, 20
25. Kuboniwa, Masaaki (1997), "Economic Growth in Postwar Russia; Estimating GDP", Hitotsubashi Journal of Economics, 38, 1:21-32
26. MITI 2000: 122-3) (White paper on international trade: general remarks)
27. MoFA (2002), Japan's FTA Strategy (Summary), Ministry of Foreign Affairs, October 2002 Retrived from on 2003-02-14 <http://www.mofa.go.jp/policy/economy/fta/strategy0210.html>
28. Murrel, Peter, Karen Turner Dunn, and George Korsun (1996), "The culture of policy making in the transition from socialism: Price policy in Mongolia" Economic Development and Cultural Change 45, 175-194
29. Naoko Munakata (2001), "Evolution of Japan's Policy Toward Economic Integration", Center for Northeast Asian Policy Studies (CNAPS), The Brookings Institution.
30. Nishimura, Yoshiaki (1999) "Reconsideration on Transitional policies for the Transformation from Socialist Planned Economy to the Market Economies", The Economic Review, October 1999
31. Ramkishen S. Rajan Rahul Sen (2002) "The Japan-Singapore "New Age" Economic Partnership Agreement: Background, Motivation And Implications" paper presented at the Trade Policy Issues Workshop, 25 February - 1 March 2002, Singapore Organized jointly by the Technical Cooperation Directorate (TCD), Ministry of Foreign Affairs (MFA), Singapore; the Asian Development Bank, Manila; and the

- ADB Institute, Tokyo. Retrieved: on February 10, 2003, from http://www.adb.org/Documents/Events/2002/Trade_Policy/JAPSIN.pdf
32. Ricardo Hausmann, Dani Rodrik (2002) “Economic Development as Self-Discovery” NBER Working Paper 8952, NBER
 33. Rodrik Dani, (2000) “Can integration Into The World Economy Substitute for A Development Strategy”, ABCDE –Europe Conference in Paris June 26-28, 2000. World Bank Retrieved: January 30, 2003, from <http://ksghome.harvard.edu/~drodrrik.academic.ksg/ABCDE-Paris.pdf>
 34. Rodrik Dani, (2002) “Institutions, Integration and Geography: In Search of the Deep Determinants of Economic growth” in Rodrik, ed., In Search of Prosperity: Analytic Country Studies on Growth, Princeton University Press, Princeton, NJ, 2003
 35. Rodrik, Dani Arvind Subremanian and Francesco Trebbi,(2002) “Institutions Rule: The Primacy of Institutions Over geography and Integration In Economic Development”, CID Working paper n97, Harvard.
 36. Schiff, Maurice and Winters, L.Alan (2002) “Regional Cooperation, and the Role of International Organizations and Regional Integration” Working Paper 2872, World Bank, Washington D.C
 37. Stanley Fischer, Ratna Sahay (2000), The Transition Economies After ten Years” NBER Working Paper 7664.
 38. Tatsushi Ogita (2002), “An Approach Towards Japan’s FTA Policy” IDE APEC study Center, Working Paper Series 01/02- No.4
 39. Urata Shujiro (2003) “Formation of Economic Partnership Agreements -The Last Chance for Japan to Become a Regional Leader in East Asia” Journal of Japanese trade and industry January/ February 2003,
 40. Walter Mattli (1999),”Explaining regional integration outcomes” Journal of European Public Policy 6:1 March 1999: 1- 27
 41. WTO (2002), “Report (2002) of the Committee on Regional Trade Agreements to the General Council”, World Trade Organization 25 November 2002
 42. WTO, (2002) “Regional trade integration under transformation” WTO Secretariat, Geneva, 26 April 2002
 43. Xiaokai Yang and Dingsheng Zhang (September 2001) “Economic Development, International trade, and Income Distribution” Retrieved: January 25, 2003, from <http://www.inframarginal.com/column/xkyang/yangs-papers/Ineq1.htm>“
 44. US-China current trade and investment policies and their impact on the US economy”, oral testimony of Kevin Kearns, June 14, 2001 p125 cited in USCC report, p42

“ЗҮҮН ХОЙД АЗИЙН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ГЭРЭЭ БА МОНГОЛ” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

Ерөнхий сайд асан, УИХ-ын гишүүн Р.Амаржаргалын “Зүүн Хойд Азийн чөлөөт худалдааны гэрээ ба Монгол” сэдэвт хэлэлцүүлэг 2007 оны есдүгээр сарын 13-нд ННФ-ын Хурлын танхимд боллоо. Хэлэлцүүлгийн эхэнд ННФ-ын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал үг хэлж, илтгэгчийг танилцуулга хийсний дараа оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнөсөн юм.

Л.Хайсандай /Олон улс судлалын хүрээлэнгийн захирал/

Таны хийсэн загварт алдагдал их байх шиг байна. Үүнийг улстөртэй холбон ойлгож болох уу?

Шанхайн байгууллагын талаар сая дурдлаа. Энэ байгууллага эдийн засгийн интеграцид орж байна гэх юм. Манайх Шанхайн байгууллагад яаж хандах вэ? Олон улс судлалын хүрээлэнгээс “Оролцох нөхцөл

бүрдээгүй” гэсэн зөвлөмжийг гаргасан байгаа. Энэ нь зөв үү, буруу юу?

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Алдагдалд улс төрийн хүчин зүйлс нөлөөлж байна уу гэлээ. Яг судалгаан дээрээ алдагдлыг нь авдаггүй. Нийт худалдааныхаа эргэлтийг авчихдаг учраас алдагдлыг гаргаж ирдэггүй юм.

Шанхайн байгууллагатай холбоотой асуудлыг та хөндлөө. Манай улс одоо ажиглагчаар байгаа. Миний бодлоор энэ байгууллагын дүр төрх, үүрэг роль нь тодорхой болсон үед энэ асуудлыг авч үзэх нь зүйтэй юм.

Ази, Европын хамтын ажиллагаа болон төмөр замтай холбоотой асуудал үнэхээр анхаарал татаж байна. Азиас Европ руу хийж байгаа худалдааны эргэлт жилд 300 миллиард тонн.



Гэтэл түүний дөнгөж 2 хувийг төмөр замаар хийж байна. Автозамаар жаахан л хийгдэж байгаа. Үлдэж буй хувь нь үндсэндээ усан замаар хийгддэг. Монгол болон Хятад улсын Орос руу хийж байгаа одоогийн худалдааны эргэлт нь 30 сая шүү дээ. Үүнийг 300 сая болгочихвол гоё биз дээ. Энд асар их бололцоо бий. 98 хувь нь усан замаар хийгдэж байна. Гэтэл усан зам гэдэг нь их удаан юм байна. Үнэхээр буухиа галт тэрэг Монголоор дамжин Орос, Хятад улсыг холбож идэвхтэй ажиллавал манайд ч, бусад оронд ч хэрэгтэй.

Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ихээхэн бэрхшээл учруулдаг хүчин зүйл бол энэ юм. Тийм учраас саяхан хоёрдахь төмөр замын судалгааны төслийг хүлээлгэж өглөө. Энэ төсөл бол төр засгийн байгууллагын анхааралд гарцаагүй байх ёстой төдийгүй шийдвэр гаргаж дэмжих ёстой төсөл гэж би ойлгож байгаа. 300 миллиард тонн-оос ядаж ганц хувь нь ч гэсэн манайхаар дамждаг болчихвол үнэхээр хэрэгтэй. Тэр утгаар нь асуудалд хандах хэрэгтэй юм.

Л.Хайсандай /Олон улс судлалын хүрээлэнгийн захирал/

Манай улс Зүүн хойд Азийн бүсэд хамаарагдах уу?

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Хамаарагдаж байгаа.

Л.Хайсандай /Олон улс судлалын хүрээлэнгийн захирал/

Үүнийг яаж нотлоод байгаа юм бэ?

Америкчууд танайх Зүүн хойд Азид орно гэдэг. Гэтэл хятадууд танайх Төв Ази, Дундад Азид хамаарна гэдэг.

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Академик талаас нь авч үзвэл, жишээ нь, зарим нь Тайванийг Зүүн хойд Азийн бүсэд ороод явах ёстой гэж хэлдэг юм. Гэтэл зарим нь үгүйсгэдэг. Тэр байтугай Дорнод Сибирийг ч бас энэ бүс нутагт хамруулаад байдаг. Тэгэхээр манайх энэ бүсэд ямар нэгэн байдлаар хамрагдаад явна л даа. Явах ч ёстой. Манай улсад өөр хамрагдах бүс байх ч үгүй.

Э.Бат-Үүл /УИХ-ын гишүүн/

Манай улстөрчид, төрийн түшээд Зүүн хойд Азийн интеграцийн тухай их ярьдаг. Эдийн засгийн өсөлтийг, хөгжил дэвшлийг хангах чухал хүчин зүйл гэж.

Европын холбооны жишээг ярья л даа. Берлиний хана нурснаас хойш Европ үнэлэмжийн хувьд нэг стратегитай болсон. Өмнө нь хоёр өөр системд буюу нэг нь социалист систем, нөгөө нь капиталист системд хамаарч байсан орнууд энэ үеэс үнэлэмжээрээ нэгдсэн. Нөгөө тал нь “буруу замаар будаа тээсэн” учраас хүч чадлаа барж цагаан тугаа өргөсөн шүү дээ. Тийм учраас ялагч тал нь стандарт, болзлоо тулгасан. Энэ нь Дорнод Европын орнуудын шилжилтийн үйл явцад чухал хүчин зүйл болсон.

Харин манай улстөрчид нэг зүйлийг ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Ямар үнэлэмжтэй орнууд энд байгааг бодож үзэхгүйгээр Зүүн хойд Азийн интеграцийн тухай яриад байх шиг санагддаг. Хятад улс энэ бүс нутагт эдийн засгийн төв болдог учраас их сонирхолтой үзэл

санааг түгээдэг юм шиг. Яг үнэндээ Хятад огт өөр үнэлэмжтэй улс. Монголын талаар барьж буй Хятадын бодлогод итгэхэд их түвэгтэй. Жишээ нь, Хятад улс авилгалтай дотооддоо хамгийн хатуу тэмцэж байгаа. Бүр цаазаар авч байна. Цаазаар авдаг практик байхгүй шүү дээ. Гэсэн атлаа Монголд өгч байгаа хамгийн том авилгалын нийлүүлэлтийг нүдээ аниад суугаад байдаг. Монгол дахь авилгалыг их өөгшүүлж, улмаар Монголд стратегийн сонирхлоо тогтоох гэсэн сайн зэвсэг болгоод байх шиг. Ингэж хоёр стандартаар хандаад байгаа юм.

Харин АНУ, Европын холбоо нь хуультай. Гадаадад хөрөнгө оруулагч нар нь авилгал өгвөл шууд шоронд хийнэ. Америкт бол үйл ажиллагааг нь зогсооно. “Сийменс” компанийг хар. Хөрөнгө оруулалтын явцад гадаад улсад авилгал өгсөн учраас гээд хариуцлага тооцож байна. Тэдний стандарт нь ийм өөр. Одоо монголчууд бүгд л мөнгөний хойноос шуурж байна. Энэ нь философи болж байгаа нь аюултай үзэгдэл юм.

Зүүн хойд Азийн ирээдүйн талаар зарим судлаач эргэлзээтэй зүйлийг хэлдэг. Энэ бүс нутагт Дэлхийн I-р дайны өмнөх Европын орнууд шиг үндсэрхэг үзэл гаарна, бүс нутгийн хэмжээнд мөргөлдөх магадлалтай гэж. Түүний нэг жишээ нь хятадууд Шанхайд томоохон жагсаал хийж, япончуудын барааг худалдахгүй байх зэргээр Японы хөрөнгө оруулалт руу дайрсан алхам хийсэн. Шанхайд болсон хөл бөмбөгийн тэмцээний үеэр Хятадын үзэгчид

Японы хөл бөмбөгчдийг зодчихсон байх жишээтэй. Их түвэгтэй.

Үнэндээ Хятадын эдийн засгийн шилжилт нь Японы 30 тэрбум долларын зээл тусламжийн үр дүнд боссон шүү дээ. Энэ нь Хятадын эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлсэн. Би Японы албаны хүнтэй уулзаж байсан юм. Хятадын эрх баригчид их муухай бодлого явуулсан юм билээ. Японы зээл тусламжийн тухай нэг ч удаа ард түмэндээ мэдээлж байгаагүй. Тэгээд ард түмэн нь Японыг үзэн ядсан хэвээрээ л байж байдаг. Тийм учраас манайх интеграцийн тухай стратегийн ойлголтоо нэлээн цэгцлэх шаардлагатай. Зөвхөн эдийн засаг гэдэг утгаар нь биш, үнэлэмж талаас нь харах шаардлагатай юм биш үү. Ядуу, тогтворгүй орны хувьд хүчтэй эдийн засаг, интеграци гэхээс илүү бусад эдийн засагт нэгдэж уусах аюул байгаа юм биш биз дээ. Улстөрч хүний хувьд ингэж бодож байна.

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Хэдэн зүйлийг тодруулъя. Энэ бол загвар юм. Япон улсын оронд Америкийн худалдааны үзүүлэлтүүдийг оруулчих. Тэгэхээр Америктай чөлөөт худалдааны гэрээ хийсэн тохиолдолд яах вэ гэдэг нь гараад ирнэ. Солонгос, Австрали, Европын холбоог оруулаад тавьчих. Бас яах вэ гэдэг нь гараад л ирнэ. Ойрхон болохоор Япон улсыг оруулсан. Түүний оронд ямар ч орныг оруулаад тооцоолж болно. Тоонууд нь өөрчлөгдөөд л гараад ирнэ. Миний судалгааны ажлын гол зорилго бол

энэ загварыг ашиглаж гарч ирсэн тоон дээрээ тулгуурлаж тодорхой шийдэлд хүрч болно гэдгийг харуулж байгаа юм. Энэ үнэхээр бололцоотой загвар байна, тийм учраас үүнийг ашиглаач, энэ хүрээн дотор ажиллаач ээ гэж хэлэхийг хүсч байна.

Зүүн хойд Азийн бүс нутгийн тухай асуудлыг их зөөлөн, туйлын дипломат томъёоллоор бичсэн байгаа. Урд нь хашиж байсан алба, өнөөгийн хашиж буй албаны хүрээнд шууд нэрлэхгүй байх зүйлүүд байна л даа. Тийм учраас хамгийн болгоомжтой томъёоллыг энд оруулсан. Түүний дотор Бат-Үүлийн санааг нь зовоогоод буй асуудал бүгд тусгагдсан байгаа. Өөрөөр хэлбэл, өөр өөр үнэлэмжтэй орнуудын хооронд ямар байх бол гэдэг асуудал юм. Тойруу замаар ч гэсэн томъёолоод оруулсан байгаа. Үүнийг анхаарах ёстой. Манай улс энэ тал дээр өөрсдийн байр сууриа тодорхой болгох ёстой. Манай судлаачид энэ асуудлыг их дэлгэрэнгүй, олон талаас нь судлах байх.

Практик талаас нь авч үзвэл Япон ч, Хятад ч өөр өөр үнэлэмжтэй орон. Гэхдээ энэ хоёр орон эдийн засгийн хамтын ажиллагааны тухай асуудал ярьж байгаа. Хятад улс Австралитай хүртэл ярьж байна. Австрали ардчилсан л орон шүү дээ. Ер нь энэ талыг нь давхар харж явах ёстой юм. Дэлхий даяар ийм процесс явагдаж байна, энэ хүрээн дотор бид хаана явж байгааг судлах хэрэгтэй байна, үүний тулд ийм загвар байх хэрэгтэй. Цөмөөрөө энэ загварын бололцоог нь ашиглая. Асуудлыг судлахдаа зөвхөн эдийн засгийн өнцгөөс нь битгий хараач ээ, үүний цаана

улстөрийн хүчин зүйл нь илүү нөлөөтэй болж байгаа учраас давхар хар гэсэн санаа юм.

Ц.Баатар /Олон улс судлалын хүрээлэнгийн ажилтан/

Энэ лекцийн тухай сонсоод Зүүн хойд Азийн чөлөөт худалдааны гэрээний хэлцэл яригдаж байгаа, тэнд Монгол орох боломжийн тухай шинэ мэдээлэл юм байна гэж их сонирхож ирсэн. Гэвч энэ бол загварчлал бөгөөд хөгжлийн байж болох нэг хувилбар юм байна. Миний бодлоор Зүүн хойд Азид улс төрийн ээдрээ түвэгтэй их гүрнүүд төвлөрдөг учраас энэ бол утопи тал нь их загварчлал юм. Өсөлтийн гурвалжин гэгддэг Хятад, Оросын хүрээнд энэ асуудлыг манай төрийн тэргүүн тавих нь ямар байдаг юм бол. Нөгөө талаас нь үзвэл манайд улс төр нь давамгайлдаг байх л даа, Америк, Япон, Өмнөд Солонгостой чөлөөт худалдааны гэрээ хэлэлцээр байгуулна гээд явчихдаг. Гэтэл манай улс Зүүн хойд Азид 17 жил зүтгэсэн. Өнөөдөр яст мэлхий шиг нэг л байрандаа байгаа.

Хятад улс давамгайлдаг нь үнэн. НҮБ-ын хөгжлийн тусламжийг аваад Түмэн голын орчимд худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсүүдийг байгуулчихсан. Мөн Хойд Солонгос ч чөлөөт бүсээ байгуулсан. Манай улсын хувьд эдийн засгийнх нь цар хүрээ, стандарт гээд маш их барьер үүсдэг. Тэгэхээр тийм том гүрнүүдтэй байгуулж байхаас.

Би Азийн хөгжлийн банкинд нэг төсөл санал болгосон. Зэргэлдээ оршиж буй гуравдахь хөрш болсон Казакстантай чөлөөт худалдааны

гэрээ байгуулбал ямар вэ гэдгийг судлая гэсэн төсөл. Гэтэл танай Засгийн газар Казакстаныг сонирхдоггүй, чөлөөт худалдааны асуудалд анхаарал ч тавьдаггүй, манайх Засгийн газрын чинь түвшний бодлогыг дэмждэг болохоос биш, аль нэг хувийн бодлогыг дэмждэггүй гэж хэлсэн. Та энэ талаар ямар бодолтой байна вэ?

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Энэ бол бололцоотой загвар. Та Монгол, Казакстаны хоёр талын худалдааны бүх данний-г оруулаад орон зай гэсэн хүчин зүйлийг нь нэмээд регресс хийгээд үз л дээ. Тэгэхээр ерөнхий нэг тоо гараад ирнэ. Энэ бол цэвэр эконометрикийн асуудал шүү дээ. Гарч ирсэн тоон дээр нь ямар интерпретаци хийх нь эдийн засагч хүний өөрийн авъяас юм.

Р.Раш /УИХ-ын гишүүн/

Даяаршил, интеграцчилалын хүрээнд чөлөөт худалдааны гэрээ яригдаж байгаа байх. Жижиг үндэстэнүүд, тухайлбал, Монгол улсын хувьд энэ асуудал дээр яаж хандаж, энэ загварыг яаж ойлгож болох вэ?

Даяаршилд бид болгоомжтой хандах ёстой юу. Манай зарим нэг төрийн тэргүүн дангааршил гэсэн нэр томъёог гаргаж ирж байсан. Түүнийг сонссон Францын тухайн үеийн төрийн тэргүүн их олзуурхаж дэлхийд урьд өмнө байгаагүй нэр томъёог гаргаж ирсэн гэж ярьсан тухай би сонссон. Яг сайн мэдэхгүй. Даяаршлыг энэ загвартайгаа холбон тайлбарлана уу?

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Энэ бол гарч ирэх л асуудал. Судлаад явахаар тулаад л очно. Жишээ нь, би Хятадтай байгуулбал яах вэ гэдгийг судлаагүй. Залуу судлаачид болон сонирхогчид үүнийг судлахыг үгүйсгэхгүй. Энэ загварчлалын нэг давуу тал нь юуг хийж болохгүй вэ гэдгийг бас хэлнэ. Өөрөөр хэлбэл, Монгол улсын төрийн бодлогын хүрээнд юу нь ашигтай, юу нь ашиггүй вэ гэдгийг гаргаж тавих бололцоо бий гэсэн үг.

Даяаршлын асуудал дээр бид байтугай Нобелийн шагналт томоохон эрдэмтдийн байр суурь хүртэл янз янз л байгаа. Энэ нь болохгүй үр дагавар авчирч байна гэж үздэг хүмүүс ч байдаг. Нобелийн шагналт, эдийн засагч Штиглиц globalization discontent гэж хэлээд бөөн шуугиан дэгдээж байсан. Манайд ирж зөвлөгөө өгөөд л явж байсан шүү дээ.

Хоёр зүйлийг бид ялгаж ойлгох ёстой. Нэг нь субъективный хүчин зүйл юм. Хувь хүний субъект, үнэлэмж зэрэг янзын бүрийн зүйлээс хамаарсан байр суурийг ялгаж харах ёстой байх. Нөгөө нь объективный хүчин зүйл юм. Яг бодит хүчин зүйлс юу байна гэдгийг харах ёстой байх. Ялангуяа төрийн бодлого бол объективный буюу бодитой өрнөж буй үйл явцуудыг авч үзэх байдлаар хандах ёстой. Түүнээс биш надад таалагдаж байна, таалагдахгүй байна гэж асуудалд хандвал буруу замаар л явна гэж би ойлгож явдаг. Зөв ч юм уу, буруу ч юм уу. Бүү мэд.

Л.Хайсандай /Олон улс судлалын хүрээлэнгийн захирал/

Сайхан илтгэл сонслоо. УИХ-ын гишүүд Монгол улсын гадаад бодлого, гадаад судлал дээр их нэгдмэл байх хэрэгтэй юм. Бид дотооддоо хямарч болно оо. Гадааддаа хямармааргүй байна.

Хоёр хөршийн асуудлыг сайн тооцоолмоор байна. Энэ нь биднийг хаачихаад байна шүү дээ. Тэгээд гуравдахь хөршийн асуудлыг их оновчтойгоор, эрдэм шинжилгээний үүднээс тодорхойлох хэрэгтэй.

Батжав /Иргэн/

Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, ҮХЯ-ны хамтарсан чөлөөт худалдааны гэрээний төсөл байгаа. Бараа бүрээр нь судлаад гаргачихсан тав зургаан хуудастай брошур 2004 оны үед гарсан. Та түүнтэй танилцаагүй юм байна. Жишээ нь, Өмнөд Солонгос, Америк, Япон улстай тийм бараагаар худалдаа хийнэ гэх мэтээр. Манай Засгийн газрын байр суурь бол Орос, Солонгос, Хятад, Япон, Америк гэсэн таван орон байдаг. Тэд тийм хувилбарыг гаргажээ. Харин та ийм хувилбарыг гаргасан юм байна.

1997 онд манай улс Дэлхийн худалдааны байгууллагад элссэн. Европын холбооноос бидэнд хөнгөлөлт үзүүлсэн. Бид хамрагдсан байгаа. Гэтэл түүний үр ашиг ерөөсөө гарахгүй байна. Ашиглагдахгүй байна. Энэ

ажил дотоодод хийгдэхгүй байна. Чөлөөт худалдааны гэрээний хувилбар янз янз байдлаар гарчихсан байгаа. Нэгдмэл байр суурьгүй байна. Та ҮХЯ-ныхаа хийсэн ажлыг үзээгүй л явж байна. Тэгээд дөрвөн жилийн өмнө хийсэн юм гээд ярьж байна шүү дээ. Ийм байж болохгүй ээ. 2007 оны арванхоёрдугаар сарын 31-ний өдөр дуусах гэж байна.

Засгийн газрын хөтөлбөрт Дэлхийн худалдааны байгууллагын гишүүнчлэлийн давуу талыг бүрэн дүүрэн ашиглана гэж тусгасан байгаа. Гэтэл ашиглаж чадахгүй байна шүү дээ. Европын холбооны шугамаар нэг ч бүтээгдэхүүн гарахгүй л байгаа. Хоёр жил дараалж Европын холбооны гишүүн орнуудад нийлүүлсэн экспорт нь унасан. Энэ жил ахиад унах гэж байна. Гэтэл хэзээ ч биелэгдэхгүй гэрээ яриад сууж байх юм.

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Энэ судалгааг улс төр судлаач хийж байгаа юм биш. Нэгдүгээрт, энэ бол судлаачийн хувьд хийсэн академический судалгаа гэдгийг ойлгох хэрэгтэй.

Хоёрдугаарт, минийх шиг ийм судалгаа хийсэн хүн байхгүй. Яам ч байхгүй. Би яам, тамгын газрын материалуудыг мэдэж байна. Хаана, хэн, юу хийж байгааг ерөнхийд нь гадарлана. Хийсэн зүйлүүдийг нь үзсэн. Тийм учраас таны ярьж буй зүйл бол үндэслэлгүй юм.

Гуравдугаарт нь, чөлөөт худалдааны гэрээ хэлбэрээр явах уу, эсвэл, өөр хувилбарууд байж болох уу гэдгийг харах. Тухайлбал, Европын холбоотой байгуулсан гэрээ байна. Гэрээний дагуу экспортонд гаргах бололцоо нь үндсэндээ бүрдчихсэн байгаа. Тийм учраас Европын холбоотой манайх чөлөөт худалдааны гэрээтэй гэж формальный хэлж болно. Манай экспортонд гаргадаг барааны тоо цөөн учраас түүн дотроо яригдаж байгаа.

Америкийн GSP систем нь Монголд илүү таатай нөхцлийг бүрдүүлж өгсөн байдаг. Үүний дагуу Америк руу бараа бүтээгдэхүүн гаргаж арилжаа наймаа хийх бололцоотой. Гэтэл Монгол улсаас Америк руу гаргаж байгаа экспортын 0.5 хувь нь GSP-д хамрагдаж байна. Манайх энэ системээ ашиглана гэдгээ ч мэддэггүй. Хэрвээ би андуураагүй бол манайх нийт дүнгээрээ арван хэдэн мянган долларын бараа, бүтээгдэхүүнийг энд хамруулаад явж байгаа. Гэтэл 300-400 мянган долларын бараа, бүтээгдэхүүнийг хамруулж татвараас чөлөөлүүлэх бололцоо бий. АНУ руу экспортын бүтээгдэхүүн гаргаж буй компаниуд нь GSP системд хамрагдах ёстой юу, энэ бараа нь тухайн жагсаалтад байна уу гэдгийг өөрсдөө сонирхох хэрэгтэй. Хэрвээ хамрагдахаар бол апплейшн бөглөдөг ёстой юм билээ. Тэгээд манай улс танайх руу ийм бүтээгдэхүүн гаргалаа гэхэд татваргүй орчихож байгаа юм.

Өнгөрсөн жил АНУ-ын Гадаад худалдааны яамныхан Монголд ирээд энэ тухай ярьж

байсан. Тэд бүрдүүлээд өгсөн бололцоог ашиглаач ээ гэдэг. 3400 нэр төрлийн бараа байна, Америк руу ямар ч татваргүй оруулах бололцоотой. Танайх буурай хөгжилтэй орон учраас нэмээд 1450 нэр төрлийн бараа бий. Дотроо дэд ангиллын гээд өчнөөн юм байгаа. Энэ бүхнийг та нар ашиглаач ээ. Танай гаргаж буй ихэнх бүтээгдэхүүн энэ ангилалд багтаж байна шүү дээ гэж хэлдэг. Бүр Америкийн хорьдог оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн дээрээ хүртэл манайд таатай нөхцлийг бүрдүүлээд өгчихсөн байгаа. Харамсалтай нь манайх үүнийг мэддэггүй. Яам, тамгын газрууд нь ч үүнийг сурталчлахгүй байгаа юм.

Европын холбоотой байгуулсан гэрээгээр 7200 нэр төрлийн бараа байгаа. Манай экспортонд гаргаж буй бараа, бүтээгдэхүүнүүдийг аваад үзвэл бараг ямар ч татваргүй орохоор байгаа ч энэ бололцоогоо ашиглаж чадахгүй байна. Чөлөөт худалдааны гэрээ гэж сонгодог нэр томъёоллоор нь ярьж байгаа болохоос япончууд үүнийг янз янзаар нэрлэдэг.

Ер нь энэ фактоороор дамжуулж гуравдахь хөршийн асуудал, тусгаар тогтнолын асуудал, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдэх нь нэг хувилбар байж болох юм гэсэн үүднээс академический судалгаа хийгээд танилцуулж байгаа юм.

Б.Арвинбаяр /ШУТИС-ийн ХБТС-ийн багш/
Бүтээгдэхүүн байж л худалдаа хийнэ. Гэтэл манай улсад үйлдвэрлэл бараг байхгүй. Ийм бага үйлдвэрлэлтэй газарт чөлөөт худалдаа яригдахаар түвшний лимит байдаг уу. Өөрөөр

хэлбэл, нийт эргэлт нь тийм түвшинд хүрч хөгжсөн бол тийм хэмжээний, тийм нэрийн бүтээгдэхүүн гаргана гэх зэргээр. Одоогийн манай гадагшаа гаргаж буй бараа нь оюуны багтаамж муутай түүхий эд л байгаа шүү дээ.

Ерээд онд Зүүн Европын улсад социалист систем задарсан. Тэгэхээр бидний гарааны цэг нэг байсан уу. Монгол улсыг нэг улс, хоёр иргэншил гэж би боддог. Энэ талаар та ямар бодолтой байна вэ?

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Лимит байдаг уу гэж байна. Жишээ нь, Иордан улсын Америктай байгуулсан гэрээ байна. Худалдааны хэмжээг нь авч үзвэл бараг юу ч байхгүй. Цэвэр улс төрийн шалтгаанаар байгуулчихсан. Америкийн Карибын тэнгисийн болон Латин Америкийн зарим оронтой байгуулж байгаа гэрээнүүд нь улс төрийн шинж чанартай. Улс төрийн өнгө аяс гарцаагүй байгаа юм.

Цэвэр эдийн засгийн утгаар нь авч үзвэл Америк, Монголын жилийн худалдаа нь Сингапур, Америкийн хагас өдрийн худалдаатай тэнцэж байгаа. Энэ бол юу ч биш. Монгол, Японы жилийн худалдаа нь Япон, Сингапурын 1.5 өдрийн худалдаатай тэнцэж байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн утгаараа цаад орнуудад сонирхохоор зүйл аягүй бага. Үүнийг бүгд хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Манай төр засгийн нөхдүүд энэ асуудлыг Америк, Япон улсад тавихаар нөгөөдүүл нь та

нар өөр юм ярь л даа гэдэг. Яахав, анхааралдаа авлаа, хүсэлтийг чинь судлая л гэж ярьж байгаа болохоос биш, үнэнийг хэлэхэд дэндүү бага. Бид нар цаад улс төрийн санааг нь гуравдахь хөршийн фактор болгож ашиглаж чадах уу, үгүй юу гэдэг зүйл энд яваад байгаа юм.

Гарааны цэг нэг байсан уу гэж байна. Миний хийсвэрлэж байгаагаар төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай, нэг намын дарангуйлалтай социалист орнууд байсан уу гэвэл байсан, ерээд оны үед шилжилтийг эхлүүлсэн гэвэл эхлүүлсэн гэдэг утгаар нь авч үзээд ерөнхийдөө гарааны нэг цэгээс эхэлсэн гэж байгаа юм. Түүний дотор янз янзын фактор нөлөөлж байсан. Тухайлбал, Польш улс Дэлхийн 2-р дайны дараа социалист болсон шүү дээ. Тийм учраас зах зээлийн ой санамж, туршлага, уламжлал байсан л зүйл. Тэр үедээ жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоог маш сайн хөгжүүлж байсан. Югославыг аваад үзье. Ямархуу янзтай байлаа. Их л ойртуулъя гэж хүсвэл манайхтай хамгийн ойр нь Болгар л байсан. Гэхдээ саяын томъёоллоор шүү дээ. Эдийн засагч нар ингэж бодвол гэсэн урьдчилсан нөхцлийг заавал оруулдаг. Тэр хүрэн дотроо л яригдаж байгаа юм. Судалгаанууд янз бүр гараад байдаг нь түүнтэй холбоотой.

П.Эрдэнэжаргал /ННФ-ын гүйцэтгэх захирал/

Өнөөдрийн сэдэвтэй шууд холбоогүй ч хөгжлийн тухай ярилцаж байгаа учраас энэ асуултыг тавьж байна. Манай улс “Үндэсний хөгжлийн цогц бодлого” гэсэн баримт бичиг

боловсруулсан, удахгүй УИХ-аар хэлэлцэх гэж байгаа. Та үүнтэй танилцсан байх. Энэ талаар ямар бодолтой байдаг вэ? Польшийн баримт бичиг гэхэд манайхаас арай л ондоо юм билээ.

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Сүүлд орж ирсэн баримт бичигтэй нь би танилцсан. Их л хөдөлмөрлөсөн байна лээ. Гэхдээ бүгдийг нь батлаад, Монгол улс түүнийг баримтлаад явна гэдэг юу л бол.

2005 онд УИХ-аар Үндэсний хөгжлийн үзэл баримтлал гэсэн нэг баримт бичгийг баталсан шүү дээ. Бүтэц, агуулгын хувьд түүнтэй адил, ингэвэл сайхан хөгжчихнө гэсэн баримт бичиг. Тэр үед би УИХ-ын даргатай маргаж л байсан. Үүнийг заавал УИХ-ын тогтоол болгон баталж яах юм, бүр шаардлагатай гэж үзэж байгаа юм бол УИХ-аар ийм баримт бичгийг оруулж, түүнийг сонслоо гээд орхичихооч гэж. Яагаад гэвэл, өмнөх баримт бичиг дээр ч гэсэн, сүүлчийн баримт бичиг дээр ч гэсэн эдийн засгийн тооцоо хийхдээ урьдчилсан нөхцөл оруулчихсан байсан. Ажилгүйдлийг 3.5 хувь гээд тооцчихсон. Гэтэл 3.5 хувийн ажилгүйдэлтэй юм бол ямар ч проблем байхгүй, гайхамшигтай хөгжилтэй орон биз дээ. 3.5 хувийн ажилгүйдэлтэй юм бол яагаад хүн амын гуравны нэг нь ядуу байгаа юм. Ийм баримт бичгийг хэлэлцэхэд хэцүү. Аливаа баримт бичиг дээр урьдчилсан нөхцөл нь их чухал байдаг. Төр засгаас ийм баримт бичгийг оруулж ирж болохгүй.

Анхны хувилбар дээр хүн амын өсөлтийг жилийн 4 хувьд хүргэнэ гэж тооцоолж байсан. Гэтэл манай эмэгтэйчүүд бүгдээрээ ажил хийхгүй, 6-аас доошгүй хүүхэд гаргаж байж ойрын 10 жилд хүн амаа хоёр дахин өсгөхөөр болж байгаа юм. Энэ нь нийгмийн бодлого мөн юм уу.

Миний бодлоор иймэрхүү судалгааны ажил их өргөн хүрээнд, тодорхой чиглэл чиглэлээр хийгдэх ёстой. Гэхдээ үүнийг одоохондоо анхааралдаа авдаг, сонсдог, ерөнхий индикатор, лавлагааны материалын хэмжээнд авч үзэх нь зөв байх. Түүнээс биш, Малайз, Польшид хийчихсэн тэр хэмжээнд арай л болоогүй. Яараад байх шаардлага байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Ний нуугүй хэлэхэд бид өөрсдөө ч нарийн ширийн зүйлээ сайн мэдэхгүй байгаа шүү дээ.

Д.Шүрхүү /Олон улс судлалын хүрээлэнгийн ажилтан/

Хятад улсын Монгол дахь эдийн засгийн ашиг сонирхол гэдэг том асуудал гарч ирж байна. Ойрын судалгаагаар эрчим хүчний салбар бараг тэр чигээрээ Хятадын нөлөөнд орж эхэлж байна. Өнгөрсөн оны статистикийн дүнгээс харвал Монголын экспортын 76 хувь нь зөвхөн Хятадад нийлүүлэгдэж байна. Монголын уул уурхайн салбарын ойрын болон дунд хугацааны ирээдүйг харвал энэ экспорт хоёр гурав дахин өсөхөөр байгаа. Тэгэхээр бидэнд чөлөөт худалдааны гэрээ гэхээс илүү Монгол Хятадын хоорондох худалдааны

бодлогыг яаж явуулах вэ гэдэг асуудал чухал болчихоод байгаа юм биш үү. Үүнийг янз бүрээр л тайлбарлах байх. Эдийн засагч биш учраас жам ёсны монополь гэсэн томъёолол байдаг эсэхийг би мэдэхгүй байна. Яагаад гэвэл давахад хүнд зүйлүүд байдаг.

Манай улстөрчид, бодлого боловсруулагчид, судлаачид нийлж байгаад Монгол улсын эдийн засагт тодорхой хэмжээний барьер, тариф тогтоогоод үүнээс гарах арга замыг эрэлхийлэх хэрэгтэй байна. Жишээ нь, хөрөнгө оруулалтын хувьд яах вэ гээд. Тэгэхгүй бол Монгол улс 5-10 жилийн дараа Хятадын том зах зээлээс хараат, худалдааны бараг 80-90 хувь нь зөвхөн Хятадтай хийдэг байдалтай болох нь ээ. Энэ талаар та ямар бодолтой байна вэ?

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Би энэ бүс нутагт гол тоглогч нь АНУ юм гэдгийг илтгэлдээ дурдсан. АНУ-ын Хятадын талаар явуулж байгаа бодлого нь тус улсыг аль болохоор юманд татан оролцуулах байдаг. Түүний давуу тал нь дүрэмгүй тоглодог байсан товаришийг нэг юманд татаж оролцуулж дүрмээр тоглуулдаг болгочихож байна. Дэлхийн худалдааны байгууллагад Хятад улс элссэнээрээ дүрэмд баригдаад эхэлсэн. Яах ч арга байхгүй. Нэгэнт л чи Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн юм бол энэ дүрмээр ажилла гэж байна. Тэгэхээр энэ бол их чухал зүйл юм. Түрүүн Бат-Үүл гишүүн Хятад улс хоёр стандарттай гэж ярьж

байсан. Гэтэл OECD-ийн дүрмээр үүнийг зохицуулдаг. Ямар ч газар өрсөлдөж байгаа тохиолдолд авилгал зэрэг аргыг хэрэглэж болохгүй гэсэн дүрэм бий. Түүний гишүүн 24 орон байгаа. Сийменстэй холбоотой асуудал OECD-гийн дүрмээр зохицуулагдаж байгаа юм. Тийм учраас Хятад улсыг иймэрхүү байгууллагуудад татан оролцуулж олон улсын хүлээн звшөөрөгдсөн дүрэм журмаар тоглуулдаг болгох асуудал их чухал фактор. Энэ чиглэлээр нэлээн ажиллах ёстой болов уу.

Натуральный монополь байж болох уу гэж байна. Ер нь байгаа. Байхдаа бодлоготойгоор ашигладаг. Тухайлбал, ДХБ-ын гишүүн болчихлоо. Аль нэг улсыг ялгаварлан гадуурхах ёсгүй. Ямар нэг нөхцөл гаргаж өгсөн бол бусад оронд ч гэсэн тэр нөхцлөө өгөх ёстой. Гэтэл бодлогын хувьд нэг гүрнийг оруулмааргүй байна. Энэ хоёрыг би оруулчихаад энэ нөхрийг оруулмааргүй байгаа юм. Тэгэхээр ямар арга замыг ашигладаг вэ гэвэл тарифын бус барьер гэж бий. Түүнийг маш хүчтэй ашигладаг. Жишээ нь, Америкийн нэгдсэн улс, Европын холбооныхон түүнийг яаж ашигладаг юм бэ гэдгийг Мита гэдэг тоглоомын үйлдвэр дээр харагдлаа. Америкт авчирсан хүүхдийн тоглоом доторх тугалганы хэмжээ нь стандартаас их байна гэж Хятад улс 500-гаад сая долларын тоглоомыг татан авч байгаа юм. Энэ бол Хятадыг тоглоомын зах зээл рүү оруулахгүй гэж барьж буй хэлбэр юм.

Өндөр хөгжилтэй орнууд ялангуяа

хөдөлмөрийн стандарттай холбоотой аргыг их хүчтэй хэрэглэж байгаа. Тухайлбал, энэ савыг хийхэд үйлдвэрийн газар нь тодорхой шаардлагыг хангасан байх ёстой, нэг ажилтанд ногдох чөлөөт зай нь төдөн куб метр байх ёстой гээд заачихна. Гэтэл Хятадын тийм үйлдвэрт нэг өрөөнд 20-30 хүн ч ажиллаж байгаа шүү дээ. Норм нь хангагдахгүй л байгаа. Тэгээд стандартаа гаргаж ирээд л хаах жишээтэй. Эсвэл эмэгтэй хүнийг ажиллуулж болохгүй, эсвэл, ажлын цаг нь найман цагаас хэтэрч болохгүй гэсэн тарифын бус барьер хэрэглэнэ. Сүүлийн үед үүнийг маш идэвхтэйгээр, бодлогын чанартай хэрэглээд байна. Энэ нь ДХБ-ын гэрээгээр зохицуулагдаагүй зүйлүүд юм. Манайх шиг жижиг орны хувьд үүнийг давхар бодож ажиллах ёстой. Ялангуяа бид хүнсний стандартын асуудлыг их ярьж байгаа. Энэ тал дээр янз бүрийн арга замыг хэрэглэх ёстой гэж бодож байна.

Э.Бат-Үүл /УИХ-ын гишүүн/

УИХ-аас хууль гаргаж Авилгалтай тэмцэх газар байгууллаа. Хөрөнгө орлогын мэдүүлгийг ил зарлалаа. Тэгээд үйл явцыг хараад байхад дотоод авилгалтайгаа бид ганцаараа тэмцэхэд хүчин мөхөстөх юм байна. Яагаад гэвэл маш том нийлүүлэлт урд чинь байна.

Сингапур, Гонконгийн жишээг та нар сайн мэдэж байгаа байх. Эд бол Хятад үндэсний улс, гэхдээ Английн хуулийн системтэй. Гэтэл тэд шүүх, прокурортоо итгэхгүйгээр Авилгалтай тэмцэх газраа тусад нь байгуулсан.

Учир нь, Их газрын Хятадаас нийлүүлэгдэх авилгалын хүчин чадлын эсрэг тодорхой институци тавьсан юм байна. Яагаад гэвэл коммунист дэглэмтэй улс учраас Сингапур, Гонконгийг ямар ч байдалд оруулж мэднэ гэж болгоомжилсон. Авилгалтай тэмцэх газар нь хамгаалалтын, сөрөг тагнуулын байгууллага байж.

Худалдааны ерөнхий хэлэлцээр өргөн агуулгатай болсон, янз бүрийн юм чихэж болдог гэж чи түрүүн хэллээ. Тэгэхээр бид чөлөөт худалдааны гэрээг Хятадад санал болгоё, түүн дотроо авилгалтай тэмцэх талаар хатуу заагаад өгчихье. Хамгийн гол тавих зүйл бол авилгалтай тэмцэх талаар хоёрдмол стандарт барихаа больё, нэг л стандарттай байя гэж. Зүүн хойд Азийн хэмжээнд ийм санаачлагыг Монголын тал гаргавал америкчууд, Европын холбооныхон шурхийгээд ороод ирнэ. 1990 онд ардчилал дэмжлэг авсан шиг Америк болоод Европын өргөн дэмжлэг авна. Яагаад гэвэл хөрөнгө оруулагчид ижил бус тулалдаанд орж байна шүү дээ. Монголын Засгийн газар бүс нутгийн хэмжээнд үүнийг санал болгоё. Түүгээр олон юмыг ч тээглэх боломжтой. Ер нь чөлөөт худалдааны ийм хэлэлцээрийг санал болгож болох уу?

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Болно. Энэ санаачилга гарч ирвэл их ирээдүйтэй гэж бодож байна. Гарцаагүй нэг шийдэл мөн. Бид амьхандаа нэг дүрмээр л тоглодог болох гээд байгаа шүү дээ. 17 жилийн хугацаанд дотооддоо хийж буй ганц зүйл

бол хууль гэж нэг юм байна. Тэр хуулиар амьдрах гэж оролдож байна. Практик дээр нэг хэсэг нь хуульд хамрагдаад, нөгөө хэсэг нь хамрагдахгүй янз бүр байгаа. Гэхдээ хэн нэгэн хүн өглөө ямар хөлнөөсөө боссоноос биш хуулиар л ажиллаж амьдардаг болох гэсэн энэ схем бүс нутгийн хэмжээнд бас яваад байгаа юм. OECD-гийн орнууд үүнийг их идэвхжүүлсэн. Солонгосууд түүнд их баригддаг. Монголд хүртэл зөндөө юм болж байсан. Солонгосын нэг компани манайд нэг төсөл хэрэгжүүлэх гэж байгаад авилгал өгсөн шуугиан гараад тэрийг нь америкчууд OECD дээр аваачиж тавиад бут цохиод “уйлуулсан” шүү дээ. Солонгос улс бол ичгүүр сонжуургүй хийдэг газрын нэг байсан. Одоо Солонгос улс үнэхээр том юман дээр OECD-ийн дүрмээр амьдарч эхэлж байна. Энэ асуудлыг тавьж болно гэж би бодож байна.

Б.Мөнхсоёл /ННФ-ын менежер/

Таны ашиглаж байгаа загвартай холбогдуулж нэмэлт тайлбар хэлэх гэсэн юм. Манай улс “Эдийн засгийн эрх чөлөөний индекс” гээд жил бүр гаргадаг олон улсын тайланд хамрагдаад явдаг. Түүний дотор гол анхаардаг асуудал нь олон улсын худалдаанд оролцох

эрх чөлөөний асуудал байдаг. Нэг индикатор нь тухайн улсын одоогийн эрхэлж байгаа худалдаа нь бололцоогоо хэр хэмжээгээр ашиглаж байна гэдгийг судалж үздэг. Үүнийг гаргахдаа таны эконометриксийн загвартай төстэй эконометриксийн загварыг ашигладаг. Гол үзүүлэлтүүд нь хөдөлмөрлөх насны хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, далайн эргийн урт, далайд гарцтай эсэх, тэгшитгэлээ шугаман болгохын тулд шугаман трендийг орлуулах нэг хувьсагч, дэлхийн эрэлтэд тухай улсын худалдаа нь ямар хэмжээтэй байгаа зэрэг юм. Гэхдээ үр дүнг нь тодорхойлохдоо ямар нэг улстай холбогдуулж үздэггүй. Таны загвараар бол Япон, Монгол улсын хамаарлыг гаргаж байгаа. Тэгэхгүйгээр дэлхийд тухайн улсын потенциал ямар байна гэдгийг гаргана. 2005 онд Монгол улс одоо хийж байгаагаасаа 50 гаруй хувь илүүтэй худалдаа хийх боломжтой гэж гарсан. Таны судалгаатай ижил дүн гарч байгаа юм. Гэхдээ таны загварын дутагдалтай тал нь хамаарал нь бага гарч байна. Уг нь нэг рүү дөхөж очсон бол.

Р.Амаржаргал /Ерөнхий сайд асан/

Цэвэр эконометрикс талаас нь сайжруулах ёстой юм.

ГАРЧИГ

Товч агуулга	1
Оршил.....	2
I. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа ба ЧХГ-ний зарим асуудлууд.....	5
II. Зүүн Хойд Ази дахь Улс төр ба Эдийн Засгийн хандлага	8
III. Япон ба чөлөөт худалдааны хэлэлцээр.....	13
IV. ЧХГ: Монголын гадаад худалдаанд үзүүлэх болзошгүй нөлөө	19
Төгсгөл.....	22
Ашигласан материал	26
“Зүүн Хойд Азийн чөлөөт худалдааны гэрээ ба Монгол” сэдэвт хэлэлцүүлгийн тэмдэглэл.....	29